

Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан  
 “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны  
 байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ,  
 үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 3 дугаар хавсралт

**ЗАСГИЙН ГАЗРЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ  
 АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД ӨГСӨН ҮНЭЛГЭЭ**

2019/01/29

/2018 оны жилийн эцэс/

ЗГҮАХ-т тусгагдсан, зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Зарцуулсан хөрөнгийн эх үүсвэр (сая төгрөг)	Зорилтот түвшин (хөрөнгийн хэмжээ эх үүсвэр, сая төгрөг)	Хэрэгжилтийн хувь	
						Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	%
1	2	3	4	5	6	7	8	9
<b>НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ ОНЦГОЙ БОДЛОГО</b>								
1.24. “Эрдэнэс Монгол” компани болон Оюутолгой төслийн үйл ажиллагааг эрчимжүүлж, Тавантолгой, стратегийн ач холбогдол бүхий бусад ордыг эдийн засгийн эргэлтэд оруулна.	2	Оюутолгойн далд уурхайн бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх	2016-2020	УУХҮЯ УУБГ		2,600,000.0	"Оюу толгойн зэс алтны ордыг ашиглах далд уурхайн бүтээн байгуулалтад 2018 онд 1,076.3 сая ам.доллар оруулахаар төлөвлөж, далд уурхайн хэвтээ малталтыг 11159 метр нэвтрэхээр төлөвлөснөөс 9555 метр, конвейерын налуу аманд 3474 метр нэвтрэлт хийхээс 2732 метр малталт нэвтрэж, 5 дугаар босоо амны нэвтрэлт 56 метр нэвтрэхээс 56 метр гүнзгийрсэн байна. Далд уурхайн бүтээн байгуулалтаас гадна ил уурхай, баяжуулах үйлдвэр ажиллаж байна. 2018 онд ил уурхайгаас 43328 мян.тонн хүдэр олборлож, Баяжуулах үйлдвэрт 582.6 мян.тонн зэсийн баяжмал үйлдвэрлэхээр төлөвлөснөөс үйлдвэрлэл, экспорт хэвийн явагдсан байна. Далд уурхайн ажлын гүйцэтгэл 2018.12.31-ний өдрийн байдлаар 46.2%-тай байна. Биелэлт 90%	100
						-		
	3	Цагаан суварга төслийг хэрэгжүүлэх	2016-2020	УУХҮЯ УУБГ		Уулын баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулах		40

							суварга төслийг ашиглалтад оруулахаар тусгасан. Үндэсний хөгжлийн газраас боловсруулсан “Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-т Цагаансуваргын ордыг хамруулж холбогдох санхүүжилтийг Улсын төсвийн хөрөнгөөр шийдвэрлүүлэхээр тусгаад байна. Биелэлт 90%	
<b>ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ ХАНГАХ БОДЛОГО</b>								
2.11. Чөлөөт бүсүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлж, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжиж ажиллана.	3	Замын-Үүд чөлөөт бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, батлуулах, улмаар Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төслийн хоёрдугаар ээлжийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх	2017-2020	БХБЯ		Чөлөөт бүсийн хот төлөвлөлтийн баримт бичигтэй болох, дэд бүтцийн 2 дугаар ээлжийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлэх	2017 оны 05 сарын 12-15-ны өдрүүдэд БНХАУ-д зохион баягуулагдсан "Бүс ба Зам" уулзалтанд МУ-ын ерөнхий сайд оролцохтой холбогдуулан айлчлалын удирдамж, хэлэлцээрийн сэдэвт Замын-Үүд чөлөөт бүсийн 200 га-д үйлдвэрлэлийн парк байгуулах төслийн талаар тусгуулах саналыг ГХЯ-нд хүргүүлсэн. Монгол Улсын хүнд үйлдвэржилтийн хөгжлийн хөтөлбөр, төлөвлөлтийг хөрш орнуудын үйлдвэржилт, хөгжлийн чиг хандлагатай уялдуулах чиглэлээр 2018.04.01-07-ны өдрүүдэд холбогдох ажилтнууд БНХАУ-ын зарим хилийн боомтын ойролцоох хүнд үйлдвэрлэл, аж үйлдвэрийн паркийн үйл ажиллагаатай танилцав. Энэхүү ажлын хүрээнд Дорноговь, Өмнөговь аймгийн боомт, БНХАУ-ын ӨМӨЗО-ны хүнд үйлдвэр, аж үйлдвэрийн паркийн үйл ажиллагаатай танилцаж, холбогдох санал, дүгнэлтийг боловсруулж, 2018.05.16-нд Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн.	70
2.17. Шатахууны үнийг дэлхийн зах зээлийн үнэтэй уялдуулан үнийн дарамтыг бууруулна.	1	Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийг шинэчлэн найруулах	2017-2018	УУХҮЯ ТБГ		- Холбогдох байгуул лагуудтай хамтарсан ажлын хэсэг байгуулж, хуульд өөрчлөлт оруулах	Хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах ажлын хүрээнд ХЗДХС/УУХҮС-ын 2017.12.13-ны өдрийн хамтарсан А/298/А/240 тоот тушаалаар батлагдсан ажлын хэсгийг байгуулан ажиллаж “Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль”-ийн нэмэлт өөрчлөлтийн төслийг боловсруулж, “Газрын тосны бүтээгдэхүүний тухай” хуулийн төслийг боловсруулж ЗГ-ын 2018 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж дэмжигдсэн. Дээрх ажлын хэсгийн хүрээнд уг хуулийн давхардал хийдэл, зөрчлийг арилгах замаар шинэчлэн найруулахгүйгээр нэмэлт өөрчлөлтүүдийг хийв. Мөн 2018.10.24-ний өдрийн Засгийн газрын хуралдаанаар Ашигт малтмалын тухай, Газрын тосны тухай, Газрын тосны бүтээгдэхүүний тухай болон бусад хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцээд УИХ-д өргөн мэдүүлэхээр болсон.	100

	3	Алслагдсан бүс нутгийн шатахууны үнийг төвийн бүстэй ойролцоо түвшинд барих бодлогыг баримтлах	2016-2020	УУХҮЯ ТБГ	Газрын тосны бүтээгдэхүүний хил үнэ, валютын ханшийн өөрчлөлт болон бусад холбогдох зардалтай уялдуулан шатахууны жижиглэн борлуулж буй үнийн зохицуулалтыг хийх	Роснефть компанийн удирдлагуудтай хийсэн удаа дараагийн уулзалтаар газрын тосны бүтээгдэхүүн импортлогч компаниудын “Бүтээгдэхүүн нийлүүлэх үндсэн гэрээ”-нд заасан үнэ тооцох томъёололд өөрчлөлт оруулж, 2018.05.01-ний өдрөөс бүс нутаг, бүтээгдэхүүний төрлөөс хамааран шатахууны үнийг 20-40 ам.доллараар бууруулахаар тохиролцсон. Энэ нь алслагдсан бүс нутгийн шатахууны үнийг төвийн бүстэй ойролцоо түвшинд барих томоохон ахиц байв. 2018.02.23-ны өдрийн ЗГ-ын 59 дүгээр тогтоолоор “Газрын тосны бүтээгдэхүүний хангамж, үнийг тогтворжуулах ажлыг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтарсан Зөвлөлийн бүрэлдэхүүн”-ийг шинэчлэн батлуулсан. Зөвлөлийн хуралдааныг 2018 оны 1, 6, 10 дугаар сард тус тус зохион байгуулж, шатахууны үнийн асуудлаар хэлэлцэн Зөвлөмжийг гарган хэрэгжүүлж ажиллав. 2018.10.03.-ны өдрийн ЗГ-ын хуралдааны 20 дахь асуудал Газрын тосны бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс урьдчилан сэргийлэх талаар авах зарим арга хэмжээний тухай ЗГ-ын тогтоолын төслийг хэлэлцүүлэн 41 дүгээр тэмдэглэлийг гаргуулсан. Засгийн газрын 2018.01.24-ний өдрийн 26 дугаар тогтоолоор А-80 болон Аи-92 маркийн автобензиний онцгой албан татварын хэмжээг “0”-лэн тус бүтээгдэхүүний жижиглэн борлуулалтын үнийн огцом өсөлтийг саармагжуулсан. Мөн импортлогч компаниудын татан авалтыг нэмэгдүүлж, нөөц бүрдүүлэх замаар шатахууны жижиглэнгийн борлуулалтын үнийг тогтвортой хадгалж ирсэн. Гэсэн хэдий ч дээрх Онцгой албан татварын зохицуулалтыг хийснээс хойш өөр нэмэлт өөрчлөлт, зохицуулалтыг хийгээгүй тул гадаад зах зээлийн үнийн хэлбэлзэл, валютын ханшийн өсөлтөөс жижиглэн борлуулах үнэ 2018 оны 2 дугаар сараас хойш бүс нутгаас хамааран литр тутамдаа 300 орчим /270-353/ төгрөгөөр нэмэгдсэн. Харин 2018 оны 11 дүгээр сараас дэлхийн зах зээл дээр газрын тосны үнэ буурсантай холбоотойгоор 12 дугаар сард нийлүүлэх газрын тосны бүтээгдэхүүний үнэ өмнөх сартай харьцуулбал тонн тутамдаа 82-148 ам доллараар буурч орж ирсэн нь сарын дунд үеэс жижиглэнгийн үнэд эерэгээр /литрт тутамд ДТ-50₮ орчим, автобензин-200₮ орчим/ нөлөөлөхөөр байна. Иймээс газрын тосны бүтээгдэхүүн импортлогч аж ахуйн нэгжүүдэд шатахууны үнээ бууруулах шаардлагыг тавьж, 2018.12.07-ны өдрөөс Аи-92 автобензиний үнийг зарим томоохон аж ахуйн нэгжүүд 100 орчим төгрөгөөр бууруулсан. Мөн 2018 оны 12 дугаар сарын 25-ны	100
--	---	--	-----------	-----------	--	--	-----

						<p>өдрөөс эхлэн Аи-80, Аи-92 автобензиний жижиглэнгийн үнэ Баян-Өлгий, Говь-Алтай, Баянхонгор аймгуудаас бусад аймаг, хотуудад 45-50 төгрөгөөр бууруулснаар Аи-92 шатахууны үнэ нийтдээ 150 төгрөгөөр буураад байна. Цаашид 2019 оны 1 дүгээр сарын хилийн үнэ буурсантай холбогдуулан шатахууны жижиглэнгийн үнэ үе шаттайгаар буурах бололцоо бүрдээд байна. ОХУ-ын “Роснефть” компаниас нийлүүлж буй шатахууны 2019 оны 1 дүгээр сарын хилийн үнэ өмнөх сартай харьцуулахад бүтээгдэхүүний төрлөөс хамааран тонн тутамдаа 86-107 ам.доллараар буурч, Аи-92 автобензин 531 ам.доллар/тн, дизелийн түлш 599 ам.доллар/тн болоод байна.</p>	
4	Улсын болон компанийн нөөцийг бүрдүүлэх	2018	УУХҮЯ ТБГ	Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 13.1-ийг хангах	<p>2018 онд газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөц бүрдүүлэх 21 аж ахуйн нэгжийн бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг агуулахын байршлуудаар нь нэгтгэн Төв, Баруун, Зүүн гэсэн 3 бүст хуваан хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллав.</p> <p>-ЗГ-ын 2012.11.27-ны өдрийн 126 дугаар тогтоолоор батлагдсан “Газрын тосны бүтээгдэхүүн импортоор оруулж, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхэлж байгаа компанийн нөөц бүрдүүлэх журам”-ын дагуу “Газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөцийн хэмжээг шинэчлэх тухай” ЗГ-ын тогтоолын төсөл болон 2019 онд газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөц бүрдүүлэх аж ахуйн нэгжүүдийн нэрсийн жагсаалт, бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг танилцуулгын хамт нэгтгэн боловсруулж, 2018.10.24-ний өдрийн ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн 322 дугаар тогтоолоор батлуулсан. Тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд АМГТГ нь газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөл эзэмшигч 21 аж ахуйн нэгжтэй компанийн нөөц бүрдүүлэх гэрээг 2018.01.25-ны өдөр байгуулсан.</p> <p>-2012 оны төсвийн хөрөнгө болон ЗГ-ын эрсдлийн сангийн хөрөнгөөр бүрдүүлсэн 12.7 мянган тонн улсын нөөцийн шатахууныг аж ахуйн нэгжүүдтэй сэлгэх гэрээ байгуулан хадгалуулж байна. УУХҮСайдын 2018.06.18-ны өдрийн 01/1670 албан тоотыг АМГТГ-т хүргүүлж, “Ник” ХХК, “Шунхлай групп” ХХК, “Монсуль” ХХК, “Магнай Трейд” ХХК, “Ойн бирж” ХХК-иудтай байгуулсан гэрээг 2019.05.01-нийг хүртэл сунгаж гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан.</p>	100	

5	Аймаг, нийслэл, сумдын хэрэглээнд үндэслэн шатахуун түгээх станц, агуулахын оновчтой сүлжээг бий болгох	2018-2020	УУХҮЯ ТБГ		Холбогдох байгууллагуудтай хамтарсан ажлын хэсэг байгуулж, судалгааны ажлыг эхлүүлэх	АМГТГ-ын даргын 2018.05.03-ны өдрийн А/61 дугаар тушаалын дагуу хамтарсан ажлын хэсэг ажиллаж, хүн амын нягтаршил ихтэй хот, суурин газар болон төв замын дагуу үйл ажиллагаа явуулж байгаа газрын тосны бүтээгдэхүүний агуулах, шатахуун түгээх станц, хийн байгууламжуудын улсын үзлэгийг зохион байгуулсан. Үзлэгээр Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ, Увс, Ховд, Өмнөговь, Дундговь, Дорноговь, Говьсүмбэр, Говь-Алтай, Сүхбаатар, Дорнод зэрэг нийт 12 аймгийн 120 суманд байрлах агуулах, түгээх станцуудын техник технологийн байдалд түвшин тогтоох үзлэг зохион байгуулсан ба үзлэгт хамрагдсан компаниудын шатахуун хадгалах савны бүртгэлийг шинэчилж байна. Аймаг, нийслэл, сумдын хэрэглээнд үндэслэн шатахуун түгээх станц, агуулахын оновчтой сүлжээг бий болгох судалгааны ажлын хүрээнд: 1.ArcGIS форматын Web хийлгэж байгаатай холбогдуулан газрын тосны бүтээгдэхүүний агуулах, шатахуун түгээх станц, шингэрүүлсэн шатдаг хийн хий цэнэглэх станц, автомашин хийгээр цэнэглэх станцын холбогдох мэдээллүүдийн талаарх судалгааны ажлыг эхлүүлсэн. 2.Австрали-Монголын Эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөрийн (АМЕР) төслийн хүрээнд ArcGIS Explorer дээр суурилсан Үндэсний Геологи, Эрдэс Баялгийн Мэдээллийн Сан Төсөл буюу МонГеоКолл системд хийн болон шатахуун түгээх станцуудын байршлын цэгүүдийн мэдээллийг нэгтгэсэн. 3.ArcGIS форматын программын сүлжээнд Улаанбаатар хот болон 21 аймгийн агуулах, түгээх станцын мэдээллийг нэгтгэн оруулсан. Улсын хэмжээнд улсын үзлэгийн шинэчилсэн дүнгээр 110 агуулах, 1289 шатахуун түгээх станц, 12 шингэрүүлсэн шатдаг хий хадгалах агуулах, 86 гаруй шингэрүүлсэн шатдаг хий түгээх станцуудаар дамжуулан газрын тосны бүтээгдэхүүний хадгалалт, түгээлт, борлуулалтын үйл ажиллагаа явуулж байна.	100
6	Шатахуун импортлох, үйлдвэрлэх, хадгалах, бөөн болон жижиглэнгээр борлуулах үеийн чанарын хяналтын	2016-2020	УУХҮЯ ТБГ	100.0	Ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн чанарын хяналтын тогтолцоог сайжруулах төлөвлөгөө боловсруулах	“Газрын тосны бүтээгдэхүүний тухай” хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөлд газрын тосны бүтээгдэхүүнд чанарын хяналт хийх, журам боловсруулахтай уялдуулан холбогдох заалтуудыг тусгав. Хуулийн төсөл 2018.10.24-ний өдрийн ЗГ-ын хуралдаанаар хэлэлцэгдэн УИХ-д өргөн мэдүүлэхээр болсон. -УУХҮСайдын 2018.01.07-ны өдрийн А/224 тоот тушаалыг үндэслэн УУХҮЯ, МХЕГ, НМХГ, АМГТГ зэрэг газруудаас нийт 18 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулсан. Ажлын хэсгийн хүрээнд зарим компаниудад хууль, журмын хэрэгжилт, хэрэглэгчдийг стандартын шаардлага хангасан газрын тосны	100

		ТОГТОЛЦООГ САЙЖРУУЛАХ				<p>бүтээгдэхүүнээр хангаж байгаа эсэхийг тогтоох, үнэлэлт, дүгнэлт өгөх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, хууль, журмыг хэрхэн хэрэгжүүлж ажиллаж байгааг шалгах ажлын хүрээнд дээрх газруудын үйл ажиллагаатай газар дээр нь танилцан ажилласан. Ажлын хэсэг шалгалтын үр дүнгийн талаарх тайлан, дүгнэлтийг 2018.10.18-ны өдрийн УУХҮЯ-ны Удирдлагын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, 08 тэмдэглэлээр цаашид авах арга хэмжээний талаарх шийдвэр гаргуулсан.</p> <p>-Эрдэс баялгийн сорилтын лабораторийн итгэмжлэлийн техникийн хорооны 2018.05.03-ны хуралдаанаар MNS ISO/IEC 17025:2007 стандартын шаардлагыг хангасан АМГТГ-ын Уул, уурхай, лабораторид газрын тосны бүтээгдэхүүний сорилт гүйцэтгүүлэхээр итгэмжлэлийг олгосон. Ингэснээр шатахуунд чанарын хяналтыг тавих боломж бүрдэж байна. Мөн Ажлын хэсгийн төлөвлөгөөний хүрээнд МХЕГ-ын хилийн албад болон удирдах ажилтны зөвлөгөөний үеэр зохион байгуулсан сургалтанд Газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөлтэй холбогдсон нарийвчилсэн журмын шинэчлэлт, бүтээгдэхүүний чанар, стандартын талаарх мэдээлэл, танилцуулгыг хийсэн.</p> <p>- УУХҮЯ, АМГТГ, БНСУ-ын К-Петро байгууллагатай хамтран 2018.09.17-ноос 18-ны өдрүүдэд “Шатахууны чанарын хяналтын менежментийн систем, технологи, БНСУ-ын туршлага” сэдэвт семинарыг зохион байгуулсан. БНСУ-ын К-Петро байгууллагатай хамтран сургалтын хөтөлбөрийг боловсруулж, МУ-д шатахууны чанарыг тогтолцоог бий болгох чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагууд, аж ахуйн нэгжүүд мэдлэг олгохоор ажилласан. Тус семинарт төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын 120 төлөөлөгч хамрагдав.</p>	
7	Гашуун сухайт, Ханх, Хавирга зэрэг боомтуудаар бүтээгдэхүүн тогтмол импортлох ажлыг эхлүүлэх, улмаар тээвэр ложистикийн зардлыг	2016-2020	УУХҮЯ ТБГ	50.0	<p>Судалгааны ажлын үр дүнг нэгтгэж, ажлын хэсгийн зөвлөмжийг үндэслэн холбогдох шийдвэрийг гаргах</p>	70	

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

		бууруулах, өртгийг багасгах судалгаа хийх				<p>авах тухай 2018.03.12-ны өдрийн 03/653 албан тоот бичгийг АМГТГ-т хүргүүлсэн.</p> <p>-БНХАУ-ын “Чайна Ойл” компаниас Өмнөговь аймгийн Гашуун сухайт, Шивээ хүрэнгийн боомтоор автоцистернээр шатахуун импортлох, ложистикийн асуудлыг шийдвэрлэх үүднээс тусгай терминал байгуулах эсэх асуудлаар ЗТАЖЯ, АТГ, ГЕГ-т удаа дараа хандсан. ГЕГ нь тухайн боомтуудаар шатахуун импортлоход шинжилгээний лаборатори байхгүй, 2019 оны улсын төсөвт лаборатори байгуулах асуудлаар холбогдох төсвийг суулгах болсон талаар хариу ирүүлсэн. АМГТГ-аас БНХАУ-ын “Чайна Ойл” компанийн удирдлагатай уулзалт хийж, Хөх хотын газрын тос боловсруулах үйлдвэртэй танилцан 2018 онд нийлүүлж буй шатахууны хэмжээ, нэр төрөл, тээвэрлэлт болон гэрээний хэрэгжилтийн талаар үйлдвэрийн удирдлагатай санал солилцож, үүсч буй зарим хүндрэлтэй асуудлуудыг зохицуулах арга хэмжээ авсан.</p>		
<p><b>Тэргүүлэх зорилт №2.2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын тогтвортой хөгжлийг хангах зорилгоор “ЭРҮҮЛ ХҮНС-ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН” үндэсний хөтөлбөр, “ҮЙЛДВЭРЖИЛТИЙН 21:100” хөтөлбөр, “ҮНДЭСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ” хөтөлбөр, “МАХ, СҮҮНИЙ АНХДУГААР АЯН”-ыг шинээр эхлүүлж, “АТРЫН-III АЯН”-ыг үргэлжүүлэн хэрэгжүүлнэ.</b></p>								
2.48. Үйлдвэржилтийн 21:100 хөтөлбөрийг	6	“Үйлдвэржилт 21:100” хөтөлбөрийг	2016-2020	ХХААХҮЯ ХҮБГ		-	<p>ХХААХҮЯ-ны ТНБД-ын 2016 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн А/157 дугаар тушаалаар байгуулагдсан “Үйлдвэржилт 21:100 хөтөлбөр”-ийг боловсруулж батлуулах үүрэг бүхий Ажлын хэсэгт яамны төлөөлөл орж ажиллав. Ажлын хэсгээс Монгол Улсад хүнд,</p>	100

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

<p>хэрэгжүүлж, импортыг орлох экспортын чиглэлийн тэргүүлэх болон жижиг, дунд үйлдвэрлэл, хоршоо, худалдаа, үйлчилгээний салбарын татвар, эрх зүй, бизнесийн таатай орчинг бүрдүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн н дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хэмжээг нэмэгдүүлнэ.</p>		<p>боловсруулан батлуулах</p>			<p>Хөтөлбөрийг хэрэгжүүлэх</p>	<p>хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлээр хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төслүүдийн танилцуулгыг боловсруулан Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж Засгийн газрын хуралдааны 2016 оны 60 дугаар тэмдэглэл гарсан. Уг тэмдэглэлд Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуульд заасны дагуу Хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулах тухай санал гарсны дагуу ажлын хэсэг “Үйлдвэржилт 21:100 хөтөлбөрийг боловсруулж, яамдаас санал авч Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр бэлэн болгосон байна. Энэхүү ажлын хүрээнд Үндэсний аж үйлдвэрийн зөвлөл болон салбарын эрдэмтэн, доктор, ААН-үүдийн удирдлагуудтай 21:100 хөтөлбөрийн төслийг хэлэлцүүлэх ажлыг УУХҮЯ-нд 2017 оны 03 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулав. Хүнд үйлдвэрийн зөвлөлөөс 2017 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 17/47 тоот албан бичгээр ирүүлсэн саналыг Ажлын хэсэгт хүргүүлэв. ХХААХҮЯ-ны 2017 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 01/1470 дугаар албан бичгийн хавсралтаар ирүүлсэн “Үйлдвэржилт 21:100” хөтөлбөрийн төсөлд санал боловсруулж, 2017 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 01/1159 тоотоор хариу хүргүүлсэн. Засгийн газрын 2018 оны 1 дүгээр сарын 31 –ний 36 дугаар тогтоолоор 21:100 хөтөлбөр батлагдсан.</p>	
	<p>7</p>	<p>"Үйлдвэржилт 21:100" хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд 21 аймагт 100 нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэр байгуулахад санхүү, эрх зүйн дэмжлэг үзүүлж ажиллах</p>	<p>2016-2020</p>	<p>ХХААХҮЯ ХҮБГ</p>	<p>1,000,000.0</p> <p>Үйлдвэрүүдийг барьж байгуулах бүтээн байгуулалтын ажил эхлэх, үндсэн дэд бүтэц нь шийдэгдсэн үйлдвэрүүдийн үйл ажиллагааг эхлүүлэх, дэд бүтцийн бүтээн байгуулалтын 25-30 хувь нь хийгдэх</p>	<p>Үйлдвэрүүдийг барьж байгуулах бүтээн байгуулалтын ажил эхлэх, үндсэн дэд бүтэц нь шийдэгдсэн үйлдвэрүүдийн үйл ажиллагааг эхлүүлэх ажлын хүрээнд хийгдсэн ажлууд. “Дорноговь аймгийн Сайншанд сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэрт 43 га газарт “Ачааны вагон угсрах үйлдвэр”-ийг барихаар төлөвлөн газрын зөвшөөрлийг авсан. Украин улсын НПФ “Техвагонмаш” компаниар “Ачааны вагоны үйлдвэр” байгуулах төслийн ерөнхий төлөвлөлтийн зураг, үйлдвэрийн дэвсгэр зураг, төслийн тооцоо, технологийн шийдэл зэрэг тооцоо судалгааг хийлгүүлсэн. БНХАУ-ын CRRC Shijiazhuang Co.,ltd компаниар төслийн урьдчилсан тооцоо судалгааг хийлгүүлсэн. ЗТХЯ, “УБТЗ” ХНН, “БТЕГ” ХХК, ГТХЗНТөв байгууллагуудын дунд “Ачааны вагоны үйлдвэр” төслийн хэлэлцүүлэг зохион байгуулсан ба 2016 оны 10 дугаар сарын 11-ний өдөр ЗТХЯ-ны дэргэдэх Зам, тээврийн салбарын Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, санал зөвлөмжийг авсан. Тус зөвлөлийн хурлаар “Ачааны вагоны үйлдвэр” байгуулах төсөл дэмжигдсэн. Уг ажлын хүрээнд Монгол улсад анх удаа 5 ширхэг ачааны хагас вагоныг угсарч, ашиглалтад хүлээлгэн өгсөн. Мөн төмөр замын салбарын хэмжээнд бүх</p>	<p>40</p>



							төрлийн хөдлөх бүрэлдэхүүний хос дугуйг угсрах, их засвар хийх үйлдвэрийн барилгын их засварын ажил 80 хувьтай хийгдэж байна. Уг үйлдвэрт ашиглах тоног төхөөрөмж худалдан авах, хүний нөөцийн сургалтын ажлууд төлөвлөгөөний дагуу шат дараатай хийгдэж байна.		
<b>Тэргүүлэх зорилт №2.3. Геологи, уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын таатай орчинг бүрдүүлэх, уул уурхайн салбарын тогтвортой хөгжлийг хангах, олон улсын эрдсийн зах зээл дэх Монгол Улсын өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.</b>									
2.59. Монгол орны геологийн зураглал, ерөнхий эрэл, агаарын геофизик, геохими, гидрогеологи, геоэкологийн судалгааны ажлын хэмжээг нэмэгдүүлэх замаар уул уурхайн салбарын тогтвортой хөгжлийг дэмжинэ.	1	Геологийн 1:50000-ны масштабын зураглал, ерөнхий эрлийн ажлын хэмжээг нэмэгдүүлж, нутаг дэвсгэрийн 45 хувийг хамруулах	2016-2020	УУХҮЯ ГБГ	Батлагдсан – 4693.7 Гүйцэтгэл – 4540.6 Санхүүжилт – 4540.6	8,100.0	Нутаг дэвсгэрийн 42.5 хувийг хамруулж, геологийн тогтоц, ашигт малтмалын хэтийн төлвийн үнэлгээг өгөх	- Улсын төсвийн хөрөнгөөр 2012, 2013, 2014 оноос хэрэгжүүлсэн үр дүнгийн тайлантай 11 төслөөс Бурхант толгой-50, Цогт-50, Дэвсгийн нуруу-50, Улаан толгой-50, Хулгарын элс-50, Хөхөлзөгийн говь-50, Бударын чулуу-50, Шивээт уул-50, нийт 8 төслийн үр дүнг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцэж, Шивээт уул-50, Бударын чулуу-50, Хөхөлзөгийн говь-50, Цогт-50 төслүүдийн үр дүнг УУХҮС-ын А/15, А/84, А/160, А/196 дугаар тушаалуудаар хүлээн авсан. Дээрх 8 төслийг хэрэгжүүлж дууссанаар нутаг дэвсгэрийн 38.7%-ийг бүрэн бүрхсэн. Энэхүү 24,621.05 км2 талбайг бүрхсэнээр тухайн талбайд тархсан төрөл бүрийн хурдас чулуулгийн тархалт, хил зааг, нас, найрлага зэргийг тодорхойлон зурагласан бөгөөд ашигт малтмалын хэтийн төлвийг тодруулж, нийт хэтийн төлөвтэй 44 талбайг ялгасан байна. Эдгээр талбайнууд нь хуулиар хориглосон, хязгаарласан газруудтай давхцалгүй бөгөөд ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох боломжтой талбайнууд юм. - 2018 онд 18 төслийг нутаг дэвсгэрийн 4 гаруй хувьд хэрэгжүүлэн ажиллахаар төсөв, төлөвлөгөөг УУХҮС-ын 2018 оны А/03 дугаар тушаалаар батлан хээрийн судалгааны ажлыг эхлүүлсэн. Төслүүдийн 2018 оны ажлын хэмжээ, арга, аргачлал, төсвийг хэлэлцсэн ЭБМЗ-ийн дүгнэлтийг үндэслэн УУХҮС-ын 2018 оны 6-р сарын 21-ний өдрийн А/158 дугаар тушаалаар төсөл, төсөвт тодотгол хийж баталсан. Мөн 2018 онд шинээр Дөч гол-50, Бүрхтэй уул-50, Дэвийн хонгор уул-50, Модот толгой-50, Асгат уул-50, Түдэвтэй-50, нийт 6 төслийг шинээр хэрэгжүүлэхээр гүйцэтгэгч нарыг сонгон шалгаруулж зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулан судалгааны ажлыг эхлүүлсэн. Дээрх төслүүдийг 2018 онд хэрэгжүүлснээр нутаг дэвсгэрийн 43.7%-ийг судалгаанд хамруулсан. Төслүүдийн 2018 оны суурин болон хээрийн судалгааны анхдагч материалыг хүлээн авсан. Үргэлжлэн хэрэгжиж байгаа болон шинээр эхэлсэн төслүүдийн хувьд хээрийн	100

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

						судалгааны ажил бүрэн дуусаагүй бөгөөд төлөвлөгөөнд онд батлагдсан төсөв, төслийн хүрээнд ажил гүйцэтгэсэн. Нийт төслүүдийн хэмжээнд 200 орчим формац, 70 гаруй бүрдэлийн нас найрлага, хил заагийг тодруулж, 120 гаруй эрлийн талбайг одоогоор ялгаад байна.	
2	Улсын геологийн 1:200000-ны масштабын зургийг нэгтгэх	2017-2020	УУХҮЯ ГБГ	Батлагдсан - 408.5 Гүйцэтгэл - 408.5 Санхүүжилт - 408.5	600.0	- Улсын геологийн иж бүрдэл зургийг К хавтгайн хэмжээнд 2016-2020 онд нэгтгэх төслийн 2018 оны төсөв, төлөвлөгөөг УУХҮС-ын А/03 дугаар тушаалаар батлан К хавтгайн нутаг дэвсгэрийн 25%-ийг хамруулахаар хээрийн судалгааны ажлыг эхлүүлсэн. 2018 оны хээрийн болон суурин боловсруулалтын судалгааны ажлын хэмжээ, арга аргачлал, төсвийг ЭБМЗ-ийн 2018 оны 3-р сарын 29-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж УУХҮС-ын 6-р сарын 21-ний өдрийн А/154 дүгээр тушаалаар баталсан. Төслийн 2018 оны суурин болон хээрийн судалгааны анхдагч материал хүлээн авсан. Төлөвлөгөөт онд гүйцэтгэсэн суурин болон хээрийн судалгааны ажлын үр дүнд К-48, К-49 хавтгайн хэмжээнд геологи, ашигт малтмал, экологи-геологийн зургуудыг ажлын хувилбараар зохиогоод байна. - Монгол орны L хавтгайн хэмжээнд ажлыг эхлүүлэхээр төсвийг тооцон холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлсэн хэдий ч 2018 оны төсөв хязгаартай батлагдсан тул тухайн төслийг дараа оноос эхлэхээр МУ-ын нийгэм, эдийн засгийг 2019 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл болон 2019 оны төсвийн хүрээний саналд тусгуулахаар холбогдох материалыг боловсруулан 2018 оны 3-р 09-ний өдрийн 03/645 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. L хавтгайн хэмжээнд нэгтгэх төслийг 2019 оноос хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийн эх үүсвэрийг УИХ-аас баталсан тул хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангасан.	70
3				/-/	1,300.0		40

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

		Монгол Улсын баруун өмнөд хэсгийг хамарсан талбайд агаарын геофизикийн цогцолбор судалгааны ажлыг хэрэгжүүлэх	2016-2020	УУХҮЯ ГБГ		Ховд-1 талбайд алт, зэс, ураны хүдэржилт агуулсан томоохон бүсүүдийг ялгах ажлыг үргэлжүүлэх	- Монгол орны баруун өмнөд хэсэгт буюу Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай, Баянхонгор, Өмнөговь аймгуудын урд хэсгийн нийт 207,094.0 км2 талбайг хамруулан 2014-2017 онд гүйцэтгэсэн 1:200000-ны масштабын агаарын геофизикийн 5 сувгийн судалгааны Алтай-1, Алтай-2 төслүүдийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн 2018 оны 4-р сарын 12-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж, УУХҮС-ын А/159, А/161 дүгээр тушаалаар үр дүнг хүлээн авснаар нутаг дэвсгэрийн 13.2%-ийг хамруулсан. 2 төслийн үр дүнд тухайн талбайнуудын хэмжээнд 200 орчим тунамал, 36 интрузив чулуулгийн хил зааг болон далд орших интрузив чулуулгийн гүний биетийг илрүүлснээр далд хүдэржилт байж болох хил хязгаарын тоймыг гаргасан ба ашигт малтмалын хүдэржилтийн шинж тэмдгийг тодорхойлж, 36 талбайн хэтийн төлвийн үнэлгээ хийсэн. Нутаг дэвсгэрийн 6.6%-ийг хамарсан Ховд-1 төслийн гүйцэтгэгчээр шалгарсан “Алтайн хар азарга групп” ХХК-тай байгуулсан гэрээг судалгааны үндсэн ажил болох агаарын геофизикийн хэмжилтийг гүйцэтгээгүй үндэслэлээр 2018 оны 6-р сарын 15-ны өдрийн Захиалагч /УУХҮЯ-ны ТНБД/-ийн 03/1638 тоот шийдвэрээр цуцалсан. Энэ судалгааг 2019 онд шинээр хэрэгжүүлэхээр МУ-ын нийгэм, эдийн засгийг 2019 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл болон 2019 оны төсвийн хүрээний саналд тусгуулахаар холбогдох материалыг боловсруулан 2018 оны 3-р сарын 09-ний өдрийн 03/645 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. Төслийг 2019 оноос хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийн эх үүсвэрийг УИХ-аас баталсан тул хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангасан.	
4		Монгол Улсын нутаг дэвсгэрийг хамарсан геохимийн судалгаа хийх	2017-2020	УУХҮЯ ГБГ	/-/	700.0 Геохимийн суурь судалгааны ажлыг томоохон хот, суурин газруудын хэмжээнд хийж эхлэх	Геохимийн судалгааны ажлыг эхлүүлэхээр төсвийг тооцон холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлсэн хэдий ч төлөвлөгөөт оны Үндсэн чиглэл болон төсөв хязгаартай батлагдсан тул тухайн төслийг 2019 оноос эхлэхээр МУ-ын нийгэм, эдийн засгийг 2019 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл болон 2019 оны төсвийн хүрээний саналд тусгуулахаар холбогдох материалыг боловсруулан 2018 оны 3-р сарын 09-ний өдрийн 03/645 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. Төслийг 2019 оноос хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийн эх үүсвэрийг УИХ-аас баталсан тул хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангасан.	40
5						400.0		70

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

	Дэд бүтцийн бүтээн байгуулалт хийгдэх газар болон томоохон хот суурин газрын геоэкологийн болон гидрогеологийн н сэдэвчилсэн судалгааны ажил хийх	2017-2020	УУХҮЯ, БОАЖЯ ГБГ	Батлагдсан – 766.1 Гүйцэтгэл – 765.04 Санхүүжилт – 765.04	Дэд бүтцийн бүтээн байгуулалт хийгдэж байгаа нутаг дэвсгэрт геоэкологи, гидрогеологийн сэдэвчилсэн судалгааны ажлыг эхлүүлэх	Улаанбаатар хотын геоэкологи, гидрогеологи-төслийн 2018 оны хээрийн болон суурин боловсруулалтын ажлын төсөл, төсөвт хийх тодотголыг ЭБМЗ-өөр 2018 оны 4-р сарын 12-ны өдөр хэлэлцэж, УУХҮС-ын 6-р сарын 21-ний өдрийн А/156 дугаар тушаалаар батлан судалгааны ажлыг эхлүүлсэн. Төслийн 2018 оны суурин болон хээрийн судалгааны ажлын анхдагч баримт материалыг хүлээн авсан. Төлөвлөгөөт онд 1:25000-ны масштабаар 2353 км <sup>2</sup> талбайд агаар, сансрын зургийн тайлал хийж, мэдээллийн санг бүрдүүлэн, гидрогеологи, геоморфологийн зургийг боловсруулсан. Улаанбаатар хотын тодорхой хэсгүүдэд /хогын цэгүүд, хөрсний бохирдол ихтэй суурьшлын бүс гэх мэт/ цохилтот болон эргэлтэт өрөмдлөгөөр хөрс, усны дээж авч шинжилгээнд хамруулсан.	
6	Эрдэс баялгийн хэтийн төлөв бүхий хүдрийн бүс, сав газар, улсын хил орчмын нутаг дэвсгэр, дэд бүтцийн бүтээн байгуулалтын төлөвлөлттэй уялдуулан сэдэвчилсэн судалгааны төсөл хэрэгжүүлэх	2017-2020	УУХҮЯ ГБГ	Батлагдсан- 6456.3 Гүйцэтгэл - 6358.07 Санхүүжилт – 6358.07	3,200.0 Металл бус болон түгээмэл тархацтай ашигт малтмалын хэтийн төлвийн судалгааны ажлыг хэрэгжүүлж эхлэх	Бүс нутгийн хөгжлийг хангах, эрдэс түүхий эдийн нөөц, баялгийг өсгөх зорилгоор нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд тархсан голлох ашигт малтмалын судалгаа (АМС-2017)-ны ажлын 2018 оны төсөв, төлөвлөгөөг УУХҮС-ын 2018 оны А/03 дугаар тушаалаар батласан. Судалгааны ажлын 2018 оны төсөл, төсвийн тодотголыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны А/153 дугаар тушаалаар батлуулж, хээрийн судалгааны ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлсэн. Төслийн 2017 оны хээрийн судалгаа болон 2018 оны суурин боловсруулалт, геофизикийн ажлын үр дүнгээр Увс, Ховд, Баянхонгор, Өмнөговь аймгийн нутагт хэтийн төлөвтэй талбайг ялган өрөмдлөгийн ажил гүйцэтгэсэн. Төслийн суурин болон хээрийн судалгааны ажлын анхдагч материалыг хүлээн авсан. 2017 оны судалгааны ажлаар эрэл шалгалт хийсэн 216 талбайгаас хэтийн төлөвтэй 59 талбайд 2018 онд нарийвчилсан эрлийн ажил гүйцэтгэсэн. Шинээр 13 талбайг хэтийн төлөвтэй болохыг тогтоосон бөгөөд өрөмдлөгийн ажлыг гүйцэтгэн, дээжийг шинжилгээнд хамруулаад байна.	70
8	Цацраг идэвхт ашигт малтмал болон газрын ховор элементийн геологи хайгуулын	2016-2020	АМГТГ БХЗГ		Цацраг идэвхт ашигт малтмал, газрын ховор элементийн эрэл, хайгуулын ажлыг эхлүүлэх	Улсын хэмжээнд 2018 оны 12 дугаар сарын байдлаар Дорноговь, Өмнөговь, Ховд аймгийн нутагт газрын ховор элементийн 4 үндсэн орд (Лугийн гол, Хотгор, Мушгиа худаг, Халзан бүрэгтэй)-ын хэмжээнд металлуудын исэл хэлбэрээр нийт 2,985,326.3 орчим тонн, ашигт малтмалын нөөцийн нэгдсэн санд бүртгэгдсэн батлагдсан нөөц 151,139.05 тонн байна. Цацраг идэвхт ашигт малтмалын чиглэлээр хайгуулын 14, ашиглалтын 9 тусгай	70

		ажлыг төлөвлөх				зөвшөөрлийг 12 аж ахуйн нэгж эзэмшин 8 аймгийн 23 сумын нутагт нийт 524.6 мянган гектар талбайд үйл ажиллагаа явуулж байна. Газрын ховор элементийн нөөц бүхий 4,512,265.63 гектар талбай буюу 167 талбайг бусад ашигт малтмалын талбайгаас ялган Кадастрын бүртгэлийн системд бүртгэсэн байна. Цацраг идэвхт ашигт малтмалын 11 ордын мэдээлийн санг бий болгож, бүртгэл хийж байгаа бөгөөд 11 ордын 9 ашиглалтын тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр байна. “Лукрий” ХХК-ийн “Улаан нуур” ураны төсөлд шинжээч хийж үр дүнгийн тайланг эцсийн байдлаар боловсронгуй болгон ЭБМЗ-д хэлцүүлж бүртгүүлэхэд бэлэн болсон бөгөөд ордын мэдээллийг мэдээллийн нэгдсэн санд оруулахад бэлэн болоод байна. Цацраг идэвхт ашигт малтмалын хайгуулын ажилд хэрэглэх аргачилсан зөвлөмжүүдийг боловсруулах ажлыг зохион байгуулж, зөвлөмжүүдийг холбогдох материалын хамт ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэн ХХ-09-01-01, ХХ-05-2-02 дугаар зөвлөмж гарсан. Бадрах энержи ХХК-ийн MV-018915 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хайгуулын ажлын үйл ажиллагаатай танилцах, ураныг газар доор уусган баяжуулах, технологи туршилтын бэлтгэл ажлын явцтай газар дээр нь танилцсан. Төрийн өмчит Мон-Атом ХХК-аас Дорноговь аймгийн Сайншанд суманд зохион байгуулагдсан уулзалт, зөвлөлгөөнд оролцож хамтарсан төслийн үйлдвэрлэлийн туршилт эхлэхтэй холбогдуулж аюулгүй байдал, хяналт удирдлага, тулгамдаж буй асуудлуудаар мэдээлэл авч, санал солилцсон.	
9	Цацраг идэвхт ашигт малтмал болон газрын ховор элементийн нөөц бүхий ордод стратегийн хөрөнгө оруулагчдыг сонгох, хамтарсан компани байгуулах	2016-2020	УУХҮЯ, АМГТГ, ЦЭКАА БХЗГ	Стратегийн хөрөнгө оруулагчдыг сонгож, хамтарсан компани байгуулах	Стратегийн хөрөнгө оруулагчаар Франц Улстай "Арева майнс" ХХК, Чех Улстай "Гурван сайхан" ХХК-ийг тус тус сонгож, эзэмшиж байгаа ордод хамтран ажиллаж байна. Чех улсын хөрөнгө оруулалттай, хамтарсан "Гурвансайхан" ХХК, Франц улсын хөрөнгө оруулалттай "Бадрах энержи" ХХК-ний компанийн нийт хувьцааны Засгийн газарт ноогдох 15-34 хувийг төрийн өмчит "Мон-Атом" ХХК хэрэгжүүлж байна. Дулаан-Уул (MV-018914, MV-018916), Зөөвч-Овоо (MV-018915) ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийг Франц-Монголын хамтарсан Арева майнс компанийн нэр дээр шилжүүлэв. Ингэснээр хувьцаа эзэмшигчдийн гэрээний дагуу хамтарсан албан ёсоор үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Гурвансайхан компанийн эзэмшиж буй орд газруудын төрийн эзэмшлийн хувь хэмжээг шилжүүлэх ажлыг зохион байгуулахаар орд эзэмшигч төрийн өмчит компаниудтай ярилцан тохиролцох ажлыг зохион байгуулсан. Орд эзэмшигчид хооронд	70	

						хөрөнгө оруулалтын маргаан үүсч Канадын Денисон Майнз компани Чех улсын Ураниум Индастри группыг олон улсын арбитрын шүүхэд өгсөнөөс шалтгаалан хувьцаа шилжүүлэх үйл ажиллагаа түр хойшлогдоод байна. Бусад ордуудын хувьд хамтарсан компани байгуулах, стратегийн хөрөнгө оруулагчийг сонгох зэрэг ажлууд бэлтгэл шатандаа явж байна.	
	10	Цацраг идэвхт ашигт малтмал болон газрын ховор элементийн хайгуул, геологийн судалгааны ажлыг гүйцэтгэх	2016-2020	АМГТГ, ЦЭКАА БХЗГ	Хувийн хэвшилийн хөрөнгө оруулалт 20,000.0 Цацраг идэвхт ашигт малтмал, газрын ховор элементийн талбайнуудад судалгаа, эрэл, хайгуулын ажлыг эхлүүлэх	Цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа аж ахуйн нэгжүүдийн 2017 оны хайгуулын ажлын зардал, 2018 оны төлөвлөгөөний талаарх мэдээлэлийг АМГТГ-аас гаргуулан авсан ба ирүүлсэн мэдээллийг нягтлан үзэхэд тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүд 2017 онд 16.9 тэрбум төгрөгийг хайгуулын ажилд зарцуулсан бөгөөд энэ нь 2016 онтой (13.1 тэрбум төгрөг) харьцуулахад 29 хувиар нэмэгдсэн боловч 2012 оны дүнтэй харьцуулахад 2.3 дахин буурсан үзүүлэлттэй байна. Цацраг идэвхт ашигт малтмалын нөөцийн мэдээг хагас жил тутам Цөмийн Энергийн комиссын ажлын албанд хүргүүлж байна. -“Монгол орны газрын ховор элементийн металлогени, түүний хэтийн төлөвийн судалгаа” 2013-2014 онд улсын төсвийн хөрөнгөөр сэдэвчилсэн судалгааны ажил хийгдэж тайлан 2016 онд хүлээн авсан.	40
2.60. Олон улсын жишгийн дагуу Үндэсний геологийн алба, Үндэсний геомэдээллийн санг байгуулан, мэдээлэл түгээх үйлчилгээг хялбаршуулна.	1	Үндэсний геологийн алба байгуулахдаа хууль, эрх зүй, эдийн засгийн үр өгөөж, гадаад улсуудын ижил төстэй байгууллагуудын талаар иж бүрэн судалгаа хийх, санал, дүгнэлт боловсруулж, ЗГ, УИХ-аар хэлэлцүүлэн шийдвэр гаргуулах, үйл	2017-2020	УУХҮЯ ГБГ	Алба байгуулах санал, төслийг боловсруулан холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх	Үндэсний геологийн алба байгуулах ажлын хүрээнд АНУ–USGS, БНСУ- KIGAM, Англи-British Geological Survey, Хятад-Chinese Geological survey, Норвеги-The Norwegian geological survey (NGU), Финлянд-The Geological Survey of Finland (GTK), Канад-The Geological Survey of Canada, ОХУ-VSEGEI, Энэтхэг- Geological Survey of India (GSI), Австрали-The Geological Survey of Western Australia зэрэг гадаад орнуудын геологийн албадын бүтэц, үйл ажиллагааны зохион байгуулалт, хууль эрх зүйн орчныг судалж харьцуулсан дүгнэлт хийсэн. Олон Улсын жишгийн дагуу "Монгол Улсын Үндэсний Геологийн Алба"-ыг байгуулах хууль, эрх зүйн үндэслэлийн талаар судалгаа хийж, судалгааны ажлуудын үр дүнд тулгуурлан албаны бүтэц, схемийг боловсруулж, үйл ажиллагааны чиглэл, зохион байгуулалтын талаар дүгнэлт гаргаж, танилцуулга бэлтгэсэн. Салбар хоорондын уялдааг хангах зорилгоор БОАЖЯ (2018.04.09-ний 01/2151 тоот), ЗТХЯ (2018.04.09-ний 02/1547 тоот), БСШУСЯ (2018.04.03-ны 1а/3035 тоот), БХБЯ (2014.04.16-ны 01/1346 тоот)-аас албаны үйл ажиллагаа, зохион байгуулалтын талаар санал авсан. Монгол Улсын нийгэм, эдийн засгийг 2019 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлд тусгагдсан Үндэсний геологийн албаны	70

	ажиллагааг эхлүүлэх					хөрөнгө оруулалтын хэмжээг тооцоолон холбогдох газарт хүргүүлсэн. Үндэсний геологийн алба байгуулах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр тогтоолын төсөл, танилцуулгыг бэлтгэн яамдаас 2018 оны 9-р сарын 12-ны өдрийн 01/2440 тоот албан бичгээр санал авсан. Сангийн яамны зүгээс төсөвт хүндрэл учруулахгүй байх хувилбарыг боловсруулах санал /чиглэл/ өгсний дагуу төсөвт нэмэлт зардал үүсгэхгүйгээр бүтэц, орон тоо, бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулах санал бэлтгэн Сангийн яаманд 2018 оны 12-р сарын 05-ны өдрийн 01/3231 тоот албан бичгээр хүргүүлсэн.	
2	Үндэсний геомэдээллийн санг баяжуулах, нэгдсэн загварт оруулах, мэдээллийн санг эрхлэх үйл ажиллагааны журмыг боловсруулах, түгээх үйл ажиллагааг боловсронгуй болгох	2016-2020	УУХҮЯ ГБГ	Батлагдсан - 323,2 Гүйцэтгэл – 323,2 Санхүүжилт – 323,2	Эрхлэх үйл ажиллагааны журмыг батлуулж, мэдээллийг нэгтгэх төсөл хэрэгжиж эхлэх	“Үндэсний геомэдээллийн сан” хөтөлбөрийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр тогтоолын төсөл, тэмдэглэл, танилцуулга болон холбогдох судалгааны материалыг боловсруулж яамдаас санал авсан. Сангийн яамнаас өгсөн саналд энэхүү хөтөлбөр нь Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 онд шинээр боловсруулах болон үргэлжлүүлэн хэрэгжүүлэх үндэсний хөтөлбөрийн жагсаалт”-д тусгагдаагүй, Засгийн газрын 2001 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн 183 дугаар тогтоолоор баталсан “Монгол орны геомэдээллийн сан бүрдүүлэх хөтөлбөр”-ийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн Засгийн газрын хуралдаанд танилцуулан, холбогдох шийдвэрийг гаргуулсны дараа тус хөтөлбөрийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрлийг авах шаардлагатай гэсэн чиглэлийн дагуу Засгийн газрын 2018 оны 12-р сарын 05-ны өдрийн хуралдаанаар уг асуудлыг танилцуулж, хуралдаанаас 2019 оны I улиралд багтаан “Үндэсний геомэдээллийн сан” хөтөлбөрийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж шийдвэрлэсэн. “Геологи, уул уурхай, эрдэс баялгийн мэдээллийн санг эрхлэх үйл ажиллагааны журам”-ыг боловсруулан УУХҮС-ын 2018 оны А/19 дүгээр тушаалаар батлуулж, Захиргааны хэм хэмжээ тогтоосон актын улсын нэгдсэн бүртгэлийн 2018 оны 3855 дугаарт бүртгүүлсэн. Геомэдээллийн санг энэхүү журмын дагуу бүрдүүлэн баяжуулж байна. Сан хөмрөгийг 2018 онд ашигт малтмалын хайгуулын ажлын үр дүнгийн 129 тайлан, геологийн судалгааны ажлын үр дүнгийн 10 тайлангаар баяжуулсан байна. Геомэдээллийн сан-2013 төслийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн 2018 оны 4-р сарын 12-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэн УУХҮС-ын 2018 оны өдрийн А/162 дугаар тушаалаар хүлээн авсан. Энэхүү ажлын үр дүнд 1:1000000-ын масштабын геоморфологи, 1:500000-	100

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

						ны масштабын гидрогеологи, геологийн зураг, холбогдох мэдээллийн санг үүсгэн геологийн архивт тушаасан.		
2.61. Геологи, уул уурхайн салбарт хөрөнгө оруулалтыг татах эрх зүйн таатай орчинг бүрдүүлж, харилцан үр ашигтай төсөл, хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлнэ.	1	Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах	2017-2018	УУХҮЯ ГБГ	-	Хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлж, батлуулах	Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд салбарын мэргэжлийн холбоод, аж ахуйн нэгжүүд, судлаачдын төлөөллүүдийн дунд 2018 оны 6-р сарын 08-ны өдөр хэлэлцүүлэг зохион байгуулж, саналуудыг авч нэгтгэсэн. Хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, үзэл баримтлалыг боловсруулж, “Хууль тогтоомжийн тухай” хуулийн дагуу ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн судалгааны тайланг бэлтгэсэн. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох асуудлаар нэмэлт өөрчлөлт оруулах төсөл, холбогдох материалыг боловсруулсан. Эрдэс баялгийн салбарын хуулиудын хийдэл, зөрчил, давхардлыг арилгах зорилгоор холбогдох хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг ХЗДХЯ-тай хамтран боловсруулж Засгийн газрын 6-р сарын 06-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжих тухай тэмдэглэл гарсан. Тэмдэглэлийн дагуу Ашигт малтмалын тухай Газрын тосны тухай, Газрын тосны бүтээгдэхүүний тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг бэлтгэн 2018 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжүүлж 2018 оны 12 дугаар сарын 04-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.	70
	2	Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг боловсруулах	2018	УУХҮЯ УУБГ		Хуулийн төслийг боловсруулж, УИХ-аар батлуулах	"Шинээр боловсруулсан Уул уурхайн тухай хуулийн төсөлд "Ил тод байдал"-ын асуудлаар бие даасан бүлэг оруулсан. Монголын "Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (ОҮИТБС)"-ын Ажлын хэсгийн 48 дугаар хуралдааныг зохион байгуулж, ОҮИТБС-ын 2017 оны нэгтгэлийн тайлан, Засгийн газрын тогтоолын төслийг хэлэлцүүлсэн. Мөн хурлаар Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг боловсруулах Ажлын хэсгийг шинээр байгуулах, эрх зүйн зохицуулалтыг боловсруулах асуудлыг хэлэлцсэн. Биелэлт 90%	40
	4	Эдийн засгийн үр ашигтай төслүүдийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх	2016-2020	УУХҮЯ БХЗГ		Бэлэн болсон 20-иос доошгүй уурхай, уулын үйлдвэрийг ашиглалтад оруулах	Уурхай, уулын үйлдвэрийг ашиглалтад оруулах комисс нийт 7 удаа ажиллаж, 2018 оны эхний хагас жилд нийт 66 аж ахуйн нэгж хүсэлт ирүүлсэн. Комисс ажлуллахаар хүсэлтээ ирүүлсэн аж ахуйн нэгжүүдтэй холбоо тогтоож бичиг баримтын бүрдэл хангасан 21 уурхайд улсын комисс ажиллаж, цаашдын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмжийг өгч,	100



УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

						хүлээн авсан. Бусад бичиг баримтын бүрдэл хангаагүй-21, бичиг баримтын бүрдэлээ ирүүлээгүй 24 аж ахуйн нэгж байна.	
5	Гадаад орнуудтай хамтарсан геологийн судалгааны ажлын төслийг хэрэгжүүлэх, үр дүнгийн тайланг хүлээн авах	2017-2020	УУХҮЯ ГБГ	Батлагдсан - 90.0 Гүйцэтгэл – 89.9 Санхүүжилт – 89.9	Улсын төсөв 250.0  Хамтран хэрэгжүүлсэн төслүүдийн үр дүнг хүлээн авах	МУ, БНХАУ, БНСУ, ОХУ, БНКаЗУ-ын хамтарсан “Хойд, төв, зүүн Азийн гүний геологийн процесс ба металлогени” төслийн 3-р шатны ажлын үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн 2017 оны 11-р сарын 16-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэн УУХҮС-ын 2018 оны 1-р сарын 31-ний өдрийн А/16 дугаар тушаалаар хүлээн авсан. МУ, БНХАУ, БНСУ, ОХУ, БНКаЗУ-ын хамтарсан “Хойд, төв, зүүн Азийн гүний геологийн процесс ба металлогени” төслийн 4-р шатны ажлын гүйцэтгэгчийг шалгаруулан гэрээ байгуулан Монгол Алтай хэмжээнд судалгааны ажлыг эхэлсэн. Төслийн 2018 оны суурин боловсруулалтын ажлын анхдагч материалыг хүлээн авсан.	70
6	Хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх талаар гадаад орнуудаас ирүүлсэн саналыг судалж, харилцан үр ашигтай төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	2017-2020	УУХҮЯ ГБГ		Улсын төсөв 1,200.0  Харилцан үр ашигтай төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	<ul style="list-style-type: none"> <li>- ОХУ-ын Росгеолфонд-д хадгалагдаж байгаа Монгол Улсын нутаг дэвсгэрт 1960-1990 оны хооронд хийгдсэн геологи-геофизикийн тайлангуудын хуулбарыг Монголын талд шилжүүлэн авах ажил амжилттай хэрэгжиж, эхний ээлжний олон нийтэд нээлттэй 70 тайланг цахим хуулбарт хөрвүүлэн 3-р сарын 21-ний өдөр авсан. Эдгээр тайланг 4-р сарын 06-ны өдөр 70 ширхэг цахим тайлан, 12 хуудас холбогдох материалын хамт Ашигт малтмал, газрын тосны газарт хүлээлгэн өгсөн.</li> <li>- Австралийн IMARC-2018 уул уурхайн хөрөнгө оруулалтын ээлжит чуулганд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдаар ахлуулсан яамны ажлын хэсэг оролцож, Монголын эрдэс баялгийн төслүүдийг танилцуулж салбарыг сурталчилсан.</li> <li>- Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Унгар Улсын төрийн өмчит “Мечекерц инвайрметал” ХК-тай 2018 оны 2-р сарын 01-ний өдөр “Монгол Улсын геологийн салбарт хамтран ажиллах тухай” харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан Санамж бичигт “Талууд хамтын ажиллагааны санхүүжилтийн хувьд Монгол Улсад олгож болох Унгар Улсын хөнгөлөлттэй зээлийг санал болгохыг дэмжиж байна” гэж заасан. Геологийн салбарт хамтран хэрэгжүүлэх боломжтой “Тунамал хурдас дахь шижирмэг ашигт малтмалын эрэл, хайгуул” төслийн танилцуулгыг удирдлагуудад танилцуулсан.</li> <li>- Ашигт малтмалын тухайн төрөл тус бүрээр эрэл, хайгуулын ажлыг явуулах аргачилсан зөвлөмж боловсруулах ажлын хүрээнд Австрали-Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөрийн санхүүжилтээр алтны үндсэн болон</li> </ul>	70

						<p>шороон орд, төмөр, хайлуур жонш, газрын тос гэсэн 5 төрлийн ашигт малтмалын эрэл, хайгуулын ажилд хэрэглэх аргачилсан зөвлөмж боловсруулах 200 сая төгрөгийн өртөг бүхий ажлыг зохион байгуулан эхлүүлээд байна. Мөн Монгол Улсын олборлох салбарын менежментийг бэхжүүлэх Канадын СЕСМИМ төсөлтэй хамтран дахин 1 ашигт малтмалын төрлөөр уг ажлыг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангаж ажилласан.</p> <p>- БНКаЗУ-ын Элчин сайд К.Кобландинаас ирүүлсэн санамж бичиг байгуулах тухай хүсэлтийн дагуу тус улсын “Казаероспез” ТӨҮГ-ын хиймэл дагуул ашиглан зайнаас тандан судлах аргын танилцуулга уулзалтад оролцсон. Тус ТӨҮГ-тай Засгийн газрын хэмжээнд санамж бичиг байгуулах нь зохимжгүй гэсэн шийдэлд хүрч саналыг буцаасан.</p>	
<p>2.62. Уул уурхайн үйлдвэрлэл дэх төрийн оролцоог зохистой хэмжээнд байлгаж, Кадастрын бүртгэлийн системийг боловсронгуй болгож, тусгай зөвшөөрөл олгох үйлчилгээг хөнгөн шуурхай болгоно.</p>	1	<p>Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг хялбаршуулах талаар судалгаа хийж, хэрэглэгчдэд ойлгомжтой байдлаар тусгай зөвшөөрөл олгох, мэдээллийг ил тод, нээлттэй түгээх аргачлалын санал боловсруулах</p>	2017-2018	УУХҮЯ ГБГ	<p>Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох үйлчилгээ хялбар, шуурхай болох, олон нийтэд ойлгомжтой болох</p>	<p>- Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журмыг боловсруулан УУХҮС-ын 2018 оны 2-р сарын 13-ны өдрийн А/28 дугаар тушаалаар батлуулан захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд 2018 оны 2-р сарын 21-ний өдрийн 3863 дугаарт бүртгүүлсэн.</p> <p>- Улсын Их Хурлын 2017 оны 11-р сарын 10-ны өдрийн хуралдаанаар Ашигт малтмалын тухай хуулийн 17 дугаар зүйлийг өөрчлөн найруулан баталсан. Ашигт малтмалын тухай хуулийн энэхүү нэмэлт өөрчлөлтийн дагуу Засгийн газрын 2014 оны 239, 2015 оны 511, 2017 оны 37, 234 дүгээр тогтоолоор батлагдсан сонгон шалгаруулалтаар олгох 13.62 сая гектар талбайгаас хуулиар хязгаарласан, хориглосон 4.07 сая гектар талбайг хасаж, тусгай зөвшөөрөл олгох боломжтой 8.68 сая гектар талбайг ялган 2018 оны 1-р сарын 29-ний өдрөөс эхлэн хуульд заасан 45 хоногийн хугацаанд орон нутгаас санал авсны үндсэн дээр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр 4 дүгээр сарын 20-ны өдрийн 01/1086 тоот албан бичгээр хүргүүлсэн. Засгийн газрын хуралдаанаар дээрх асуудлыг хэлэлцээд МУ-ын Ерөнхий сайдаас БОАЖЯ, ХХААХҮЯ-ны саналуудыг судалж, тусгах чиглэл өгсний дагуу дээрх 2 яамтай хамтран ажиллаж, нэгдсэн санал бэлтгэсэн. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох талбайн солбицлын тухай нэгдсэн саналыг Засгийн газрын 2018 оны 8-р сарын 08-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн “Талбайн солбицол тогтоох тухай” 243 дугаар тогтоолыг гаргасан. Уг тогтоолоор нийт 237,580 солбицол бүхий 8,489,065.45 гектар талбайг сонгон шалгаруулалтад хамруулахаар тогтоон нийтэд зарлахаар шийдвэрлэсэн.</p>	100

							- Хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох ажил 2018 оны 8-р сарын 22-оос эхлэсэн бөгөөд оны эцсийн байдлаар 6 багцаар 60-н талбайд 511,189.89 га-д хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт зарласан. Үүнээс 217 мян.га талбайд 27 хайгуулын тусгай зөвшөөрөл олгож улсын төсөвт бодитоор 13,8 тэрбум төгрөг төвлөрүүлээд байна.	
2.63. Газрын тосны болон уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын ажлыг эрчимжүүлж, нөөцийг өсгөнө.	2	Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах	2018-2019	УУХҮЯ ТБГ	Холбогдох байгууллагуудтай хамтарсан ажлын хэсгийг байгуулж, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг судалж, боловсруулах	Эрдэс баялгийн салбарт үйлчилж буй багц хуулиудын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах ХЗДХС/УУХҮС-ын 2017.12.13-ны өдрийн хамтарсан А/298/А/240 тоот тушаалаар байгуулсан ажлын хэсгийн ажлын хүрээнд “Газрын тосны тухай” хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгахаар ажиллаж, мэдээллээр ханган, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Мөн газрын тосны асуудлаар татварын хөнгөлөлтийн жилийг 5 жилээр нэмэгдүүлэх, орон нутагт орох өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор НӨАТ, гаалийн албан татварын тухай хууль, төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах саналаа Сангийн яаманд 2018 оын 5-р сарын 14-ны өдрийн 01/1327 тоотор хүргүүлсэн. Газрын тосны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг томъёоллыг бэлдэж, Ажлын хэсэгт тухай бүр танилцуулж, ЗГ-ын 2018 оны 6-р сарын 6-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. Мөн газрын тосны тухай хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах ажлын хэсэгт ажиллаж, мэдээллээр ханган, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Газрын тосны асуудлаар татварын хөнгөлөлтийн жилийг 5 жилээр нэмэгдүүлэх, орон нутагт орох өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор НӨАТ, Гаалийн албан татварын тухай хууль, Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг Сангийн яаманд 2018.05.14-ний өдрийн 01/1327 тоот албан бичгээр хүргүүлсэн.	100	
	3	Газрын тосны салбарын хөрөнгө оруулалтын болон эдийн засаг, эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх	2016-2019	УУХҮЯ ТБГ	Хөрөнгө оруулагч нарт таатай эдийн засаг, эрх зүйн орчин бүрдүүлэх	Бүтээгдэхүүн хуваах гэрээг шинэчлэх тухай Засгийн газрын 2016 оны 130 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2014 оны 07 дугаар сарын 01-ний өдөр баталсан Газрын тосны тухай хууль батлагдахаас өмнө байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдийн үндсэн нөхцөлийг өөрчлөхгүйгээр Засгийн газрын 2015 оны 104 дүгээр тогтоолоор баталсан Бүтээгдэхүүн хуваах гэрээний загварт нийцүүлэн хэлэлцээр хийж шинэчлэх үүрэг бүхий ажлын хэсгийг сайдын 2016 оны А/57, 2018 оны А/12 дугаар тушаалаар тус тус байгуулж ажиллав. Газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулж буй компаниудын хувьд Ажлын хэсэг нийт 10 гэрээлэгчтэй уулзалт хэлэлцээр хийсний дүнд хайгуулын үе шатанд хэрэгжиж	100	

						<p>буй нийт 15 Бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдээс 4 гэрээг шинэчлэн байгуулж, 3 гэрээг шинэчлэн байгуулахад бэлэн болгож, 3 гэрээг шинэчлэхээр хэлэлцээ хийж байна. БХГ-нүүдийг шинэчлэх ажлын хэсгийг УУХҮСайдын 2018.01.17-ны өдрийн А/12 дугаар тушаалаар байгуулж, хэлэлцээр хийх хуралдаанд оролцон ажлын хэсгийг мэдээллээр хангаж ажилласан. БХГ-нүүдийг 2015 оны Засгийн газрын 104-р тогтоолоор батлагдсан загварт нийцүүлж шинэчлэх ажлын хүрээнд газрын тосны хайгуулын Богд IV, Онги V талбайд БХГ байгуулсан “Капкорп Монголиа” ХХК-ийн, газрын тосны хайгуулын Матад ХХ талбайд БХГ байгуулсан “Петро Матад” ХХК-ийн, газрын тосны хайгуулын Баянтүмэн XVII талбайд БХГ байгуулсан “Магнай трейд” ХХК-ийн гэрээг тус тус шинэчлэн байгуулсан. Түүнчлэн:</p> <ul style="list-style-type: none"> <li>-Нялга XVI талбайд 2018-08-27нд шинэчлэн байгуулсан</li> <li>-Богд IV, Онги V талбайд 2018-06-05-нд шинэчлэн байгуулсан</li> <li>-Баянтүмэн XVII талбайд 2018-06-08-нд шинэчлэн байгуулсан</li> <li>-Матад ХХ талбайд 2018-06-08 нд шинэчлэн байгуулсан</li> <li>-БХГ-ний хэрэгжилтийн талаар ЗГ-ын 2018.05.02-ны өдрийн болон 2018.10.03-ны өдрийн хуралдаанд тус тус танилцуулсан</li> </ul>	
4	Газрын тосны ордын ашиглалтыг эрчимжүүлж, олборлолтыг урт хугацаанд тогтвортой хадгалж, боломжит хэмжээгээр нэмэгдүүлэх	2016-2020	УУХҮЯ ТБГ		<p>Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт 1,000,000.0</p> <p>Тухайн жилийн зорилтот түвшинд хүрэх</p>	<p>Зүүн бүсийн уул уурхай, газрын тосны ашиглалтын үйл ажиллагаанд шаардлагатай эрчим хүчийг дотоод, гадаад эх үүсвэрээс хангах, нөөц эх үүсвэр бий болгох боломжийг судалж, дүгнэлт гаргах зорилгоор Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд болон Эрчим хүчний сайдын хамтарсан А/58/36 дугаар тушаалаар ажлын хэсэг 2018 оны 3 дугаар сарын 12-ны өдөр байгуулагдсан. Үүний дагуу ажлын хэсгийн гишүүд Дорнод, Сүхбаатар аймгуудад байрлах Шинь Шинь ХХК, Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК, Петровичайна Дачин Тамсаг ХХК, Цайрт минерал ХХК болон Эм эл цахиурт овоо ХХК-иудад 2018 оны 4 дүгээр сарын 2-8-ны өдрүүдэд ажиллаж, тус ажлын үр дүнд гарсан дүгнэлтийг ажлын хэсгийн 2018 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн хуралд танилцуулж, ажлын хэсгийн гишүүдээр хэлэлцүүлэн дүгнэлтийг гаргуулав. Үүний дагуу БНХАУ-аас Тамсаг ХХИ талбай хүртэл 18 км цахилгаан дамжуулах шугам татах нь зүйтэй гэсэн дүгнэлт гаргасан. Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг УУХҮЯ-ны Удирдлагын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, 2018.10.18-ны өдөр 07 дугаар тэмдэглэл гарсан. Мөн газрын тосны асуудлаар татварын хөнгөлөлтийн жилийг 5 жилээр нэмэгдүүлэх, орон нутагт орох өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор НӨАТ, гаалийн албан татварын тухай хууль, төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах</p>	70

						саналаа Сангийн яаманд 2018 оын 5-р сарын 14-ны өдрийн 01/1327 тоот албан бичгээр хүргүүлсэн. Газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдэд Үндэсний Аудитын газар болон МХЕГ-аас хийсэн шалгалтын дагуу өгсөн үүрэг даалгаварын биелэлтэд хяналт тавьж ажиллаж байна. Мөн Уул уурхайн сайдын Дорнод аймагт ажиллахтай холбогдуулан 2018 оны 5-р сарын 2-7-ны өдрүүдэд Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайд томилолтоор ажиллаж, үүрэг даалгаварын биелэлтэд хяналт тавьж ажилласан.	
5	Газрын тосны ордын дэд бүтэц, бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажлыг эрчимжүүлэх	2016-2020	УУХҮЯ ТБГ		Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт 900,000.0	Тосон-Уул XIX талбайгаас Баянхошууны хилийн боомт хүртэлх 210.7 км хатуу хучилттай авто замын 1, 2 болон 4 дүгээр хэсгүүд ашиглалтад орсон. Үлдсэн 3 дугаар хэсгийн нийт урт 52.6 км бөгөөд тус хэсгийн авто замын барилгын ажлын гүйцэтгэгчээр “Арж капитал” ХХК ажилласан. Авто замын барилгын ажил 2018.04.20-ны өдрөөс эхэлж, 2018.11 дүгээр сард 52.6 км авто замын асфальт бетонон хучилтын ажил дууссан. ЗТХЯ-ны ТНБД-ын 2018.11.13-ны өдрийн 375 дугаар тушаалаар тус авто замыг байнгын ашиглалтад авах ажлын хэсэг байгуулагдан 2018.11.22-ноос 23-ны өдрүүдэд ажиллаж, авто замыг ашиглалтад хүлээн авсан.	100
					Тухайн жилийн зорилтот түвшинд хүрэх		
6	Бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайн хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх хууль, журмыг чанд мөрдүүлж, ил тод хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх	2016-2020	УУХҮЯ ТБГ		Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт 2,000.0	БХГ-т талбайн хайгуул, ашиглалтын ажлын жилийн төлөвлөгөө, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын төлөвлөгөө, төсвийг тогтмол суулган баталж байгаа бөгөөд гэрээлэгчид байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх хууль, журмын дагуу байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх менежментийн төлөвлөгөө, хэрэгжилтийн тайланг БОАЖЯ-нд тогтмол хүргүүлэн дүгнэлт гаргуулан ажиллаж байна. -“Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг нөхөн сэргээх ажлын үр дүнг хүлээн авах” журмыг УУХҮ-ийн сайд болон БОАЖ-ийн сайд нарын 2018.02.22-ны өдрийн А/50, А/31 тоот хамтарсан тушаалаар батлуулсан ба ХЗДХЯ-ны дэргэдэх Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд 2018.03.06-ны өдрийн 3870 дугаарт бүртгүүлсэн. Журмын хэрэгжилтийг хангуулан, холбогдох байгууллагуудтай хамтран хяналт тавьж ажиллах тухай 03/655 албан тоот бичгийг 2018.03.12-ны өдөр АМГТГ-т хүргүүлсэн. -Дорнод аймгийн нутаг дэвсгэрт уул уурхай, газрын тосны үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдийн байгаль орчныг	100
					Тухайн жилд хийхээр төлөвлөсөн байгаль орчин хамгаалах ажлыг хийх, хууль, журмыг мөрдүүлж хэвшүүлэх		

						хамгаалах, нөхөн сэргээх, химийн хортой болон аюултай бодисыг ашиглах үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөө болон дүгнэлт өгөх, шаардлагатай арга хэмжээ авах, санал боловсруулах үүрэг бүхий БОЯЖСайдын ахалсан ажлын хэсэг “Петрочайна дачин тамсаг” ХХК-ийн Газрын тосны XIX, XXI талбайн үйл ажиллагаа, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлттэй холбоотой хууль, журмын хэрэгжилт, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлттэй газар дээр танилцан, дээрх компаниудын удирдлага, төлөөлөлтэй уулзалт хийж, холбогдох асуудлуудаар санал солилцон, заавар зөвлөгөө, үүрэг чиглэл өгч, зарим тулгамдсан асуудлуудыг газар дээр шийдвэрлэж ажилласан.	
7	Газрын тосны борлуулалттай холбогдсон гэрээ, хэлцлүүдийг хийж, үнэ болон худалдааны таатай нөхцөлийг бүрдүүлэх	2016-2020	УУХҮЯ ТБГ	Дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэтэй уялдуулан газрын тосны борлуулалттай холбогдсон гэрээ, хэлэлцээрүүдэд оролцож, үнэ болон худалдааны нөхцөлийг сайжруулах	2018 онд түүхий тос борлуулах гэрээ хэлэлцээрүүд хийгдээгүй ба Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн хувьд 2016 онд байгуулсан гэрээ, Доншен Газрын тос (Монгол) ХХК-ийн хувьд 2017 онд байгуулсан гэрээг тус тус сунгасан. Үүний шалтгаан нь борлуулах тосны үнийг тооцоолох аргачлал, хэмжих арга, хэмжилтийн цэг нь өөрчлөгдөөгүйтэй холбоотой. Газрын тосны хайгуулын Галба-ХI талбайд бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан “Зон Хэн Юу Тиан” ХХК-ийн туршилтын журмаар олборлосон 500 тн газрын тосыг БНХАУ-ын Шандунь мужын “Чин Юань групп” компанид худалдах гэрээний хэлэлцээрийг 2018 оны 5 дугаар сарын 29-өөс 6 дугаар сарын 3”ны хооронд БНХАУ-ын Шандунь мужын Зибо хотод хийж, түүхий тосыг туршилтын журмаар худалдаалахаар болсон. Доншен газрын тос /Монгол/ ХХК болон UNIPEC компани хоорондын түүхий тосны худалдааны гэрээний үнэ, борлуулалт, тээвэрлэлтийн өртөгийн асуудлаарх хэлэлцээрийг 2016 оны 01 дүгээр сард зохион байгуулж, гэрээг сунгасан. Петрочайна Дачин Тамсаг ХХК нь газрын тосны борлуулалттай холбогдсон гэрээ, хэлцлүүдийг хийж, үнэ болон худалдааны нөхцөлийг өмнөх жилийн нөхцөл байдалтай уялдуулан сунгасан. Тосны борлуулалттай холбогдсон хэлэлцээрт, олборлосон түүхий тосны борлуулалттай холбоотой асуудлаар гэрээлэгч нь гэрээний төслийг АМГТГ-т урьдчилан танилцуулсны үндсэн дээр гэрээг эцэслэн байгуулах, түүхий тос борлуулах асуудлаар хэлэлцээ хийхдээ өмнө нь байгуулсан гэрээний нөхцөлийг бууруулахгүй, талуудад ашигтай байх нөхцөлөөр хэлэлцээ хийх, тосны борлуулалтын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, шинээр байгуулах тохиолдолд АМГТГ-т урьдчилан мэдэгдэж,	100	

						зөвшөөрөл авах, түүхий тосонд шинжилгээ хийлгэж, хүнцэл болон мөнгөн усны агууламжийг тодорхойлох зэрэг нөхцлүүдийг тусгасан.	
8	Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу явагдаж буй газрын тосны хайгуулын ажлыг эрчимжүүлж, шинээр газрын тосны орд илрүүлэх	2016-2020	УУХҮЯ ТБГ		Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт 75,000.0	-БХГ-нүүдийг 2015 оны 3Г-ын 104 дүгээр тогтоолоор батлагдсан загварт нийцүүлж шинэчлэх ажлын хүрээнд газрын тосны хайгуулын Богд IV, Онги V талбайд БХГ байгуулсан “Капкорп Монголиа” ХХК-ийн, газрын тосны хайгуулын Матад ХХ талбайд БХГ байгуулсан “Петро Матад” ХХК-ийн, газрын тосны хайгуулын Баянтүмэн XVII талбайд БХГ байгуулсан “Магнай трейд” ХХК-ийн гэрээг тус тус шинэчлэн байгуулсан. Газрын тостой холбогдсон үйл ажиллагаа эрхэлж буй бүх ААН-үүдийн БХГ-ний хэрэгжилтийн талаар 3Г-ын 2018.05.02-ны, 2018.10.03-ны өдрийн хуралдаанаар тус тус танилцуулан 41 дүгээр тэмдэглэлийг гаргуулсан. Газрын тосны хайгуулын Баянтүмэн XVII талбайд БХГ байгуулсан “Магнай трейд” ХХК-ийн хайгуулын өрөмдлөгийн үйл ажиллагааг орон нутгаас зогсоосонтой холбоотой асуудлаар 2018.10.26-наас 28-ны хооронд Дорнод аймагт томилолтоор ажиллан, аймаг, орон нутгийн удирдлагуудтай уулзалт хийж, холбогдох мэдээлэл танилцуулгыг хийсэн. Уулзалт, хэлэлцээрүүдийн үр дүнд тухайн асуудлыг Дорнод аймгийн Чойбалсан сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018.11.09-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж, шийдвэрлэхээр тохиролцсон.	70
9	Газрын тос болон уламжлалт бус газрын тосны хуримтлал байж болох газарт эрэл, хайгуулын ажлыг эрчимжүүлэх	2016-2020	УУХҮЯ ТБГ		Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт 5,000.0	“Жи Өү Эйч” ХХК нь Газрын тосны тухай хуулийн 16 дугаар зүйлийн дагуу 2016.01.15-нд Номгон-IX газрын тосны хайгуулын талбайд НДМ хийн эрлийн ажил хийж гүйцэтгэх гэрээг хуучин нэрээр ГТГ-тай байгуулсан. Эрлийн ажлын хүрээнд өмнөх хайгуул судалгааны материалыг нэгтгэх, тойм нөөцийн үнэлгээ, хайгуулын ажлын хөтөлбөр боловсруулах ажлуудыг гүйцэтгэж, Газрын тосны тухай хуулийн 17.1-р заалтын дагуу 2016.07.21-ний өдөр дүгнэлт гаргуулсан байна. Газрын тосны тухай хуулийн 17.2-р заалтын дагуу “Номгон-IX” талбайд байгуулах нүүрсний давхаргын метан хийн 17.4-р заалтын дагуу АМГТГ-тай БХГ-ний хэлэлцээрийг хийж гүйцэтгэн 2017.05.03-ны өдөр хэлэлцэн тохирсон БХГ-ний төслийг УУХҮЯ-нд ирүүлсэн. Гэрээний төсөлд 2017 оны 8 дугаар сар, 2018 оны 2 дугаар сард яамдуудаас санал авч нэгтгэн 3ГХЭГ-т хүргүүлсэн. -Газрын тосны хайгуулын Номгон-9 дүгээр талбайд нүүрсний давхаргын метан хийн чиглэлээр Австрали Улсын хөрөнгө оруулалттай “Жи Өү Эйч” ХХК-тай БХГ байгуулах эрхийг АМГТГ-	70

						<p>ын дарга Х.Хэрлэнд олгох тухай ЗГ-ын 2018.08.22-ны өдрийн 265 тоот тогтоолыг гаргуулсан. Тус гэрээг 2018.09.18-ны өдөр байгуулсан.</p> <p>-“Говийн гарц” ХХК хуучин нэрээр ГТГ-тай 2014 онд эрлийн гэрээ байгуулж, эрлийн ажлын тайлангаа 2017 оны 2 сард АМГТГ-т хүлээлгэн өгсөн бөгөөд 2017.11.01-ний өдөр АМГТГ-ийн “Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын техникийн зөвлөл”-өөр уг тайланг хэлэлцэн хүлээн авсан. “Говийн гарц” ХХК нь газрын тосны тухай хуулийн дагуу эрлийн гэрээний хүрээнд хийгдсэн ажлын үр дүнд газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулахаар БХГ байгуулах хүсэлтээ 2018.01.03-ны өдөр АМГТГ-т ирүүлсэн. Уг төслийг судлан үзээд бүх яамдаас санал авч нэгтгэж байна.</p>	
10	Хүлэмжийн хийг бууруулах чиглэлээр газрын тосны олборлолтоос гарч байгаа газрын тосны ууссан хийг ашиглах чиглэлээр судалгаа хийх, ашиглах	2016-2018	УУХҮЯ ТБГ	<p>Гадаад эх үүсвэр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт 100.0</p> <p>Олон улсын туршлага, судалгааны үр дүнг үндэслэн боломжит хувилбарыг гаргах, хэрэгжүүлж эхлэх</p>	<p>“Дашваанжил” ХХК-иас тавьсан хүсэлтийн дагуу 2018 оны 2 дугаар сард тус компанийн төлөөлөлтэй уулзалт хийж, Тосон-Уулын ордоос олборлож буй шингэнээс ялган авч буй ууссан хийг Япон улсад шинжлүүлэх талаар хэлэлцэн шаардлагатай мэдээ, материалыг нэгтгэн хүргүүлсэн ба олборлолтын талбай дээрээс ууссан хийн дээж авах ажлыг зохион байгуулсан.</p> <p>-БХГ-т Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайн газрын тосны орд газраас олборлосон шингэнээс ялган авсан ууссан хийн хэмжээ, зарцуулалт дараах байдалтай байна. Үүнд:</p> <p>-БХГ-т Тосон-Уул XIX талбайгаас нийт 10,666,957 м3 хийг ялгасанаас, 6,432,365 м3 хийг халаах зууханд, 508,428м3 хийг цахилгаан генераторт тус тус ашиглаж, илүүдэл буюу 3,726,164 м3 хийг бамбардсан байна. Та-1 олборлолтын нэгдсэн байгууламжийн өдөр тутмын мэдээнээс харахад хүйтний улиралд хоногт дунджаар 1800м3, дулааны улиралд 1100м3 хийг цахилгаан генераторт ашигласан.</p> <p>-БХГ-т Тамсаг XXI талбайгаас нийт 8,417,740 м3 хийг ялгасанаас, 6,633,832 м3 хийг халаах зууханд, 603,523м3 хийг цахилгаан генераторт тус тус ашиглаж, илүүдэл буюу 1,180,385 м3 хийг бамбардсан. Та-2 олборлолтын нэгдсэн байгууламжийн өдөр тутмын мэдээнээс үзэхэд хүйтний улиралд хоногт дунджаар 2500м3, дулааны улиралд хоногт дунджаар 1450м3 хийг цахилгаан генераторт ашигласан байна.</p> <p>-Тосон-Уул XIX талбайн хувьд 500кВт-ын 2 хийн генератортой бөгөөд үүний нэгийг тогтмол ажиллуулдаг, Тамсаг XXI талбайн хувьд 600 кВт-ын 4 хийн генератортой бөгөөд үүнээс 1-ээс 2-ыг тогтмол ажиллуулдаг байна. Хийн генераторын хүчин чадал болон</p>	100	



УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

						тоо хэмжээг нэмэгдүүлснээр үйлдвэрлэх эрчим хүчний хэмжээг нэмэгдүүлэх бөгөөд шатааж буй (бамбардаж буй) хийг бүрэн ашигласан тохиолдолд 1.5-3 МВт орчим эрчим хүчийг гарган авах боломжтой гэж үзэж Тосон-Уул XIX талбайд шинээр 2 хийн үүсгүүр тавих асуудлыг тавьж, санал дүгнэлт гарган, ажлын төлөвлөгөө, төсөвт тусган ашиглалтанд оруулах талаар арга хэмжээ авч ажилласан. Одоогоор шинэ 2 хийн үүсгүүр нь тогтмол ажиллаж байна. Өвлийн улиралд хийн зарим хэсгийг нэгдсэн байгууламжийн халаалтад ашиглаж байна.	
11	Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй талбайд ой хээрийн түймэр гарах, тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор зурвас бүсийг байгуулах	2016-2020	УУХҮЯ ТБГ	Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт 100.0	Хаврын хуурайшилтын үе эхэлсэнтэй холбогдуулан галын аюулаас хамгаалах зурвас бүс байгуулах шаардлагыг гэрээлэгчид тавьж, Тамсаг XXI талбайн галын аюулгүйн зурвасыг үйлдвэрлэлийн бааз болон нэгдсэн байгууламжийг, мөн цооногуудыг тойруулан галын аюулгүйн бүс, Тосон-Уул XIX талбайн үйлдвэрлэлийн бааз, нэгдсэн байгууламж, цооногуудаас 20-50 метр зайтай, 5-8 метр өргөн, 3-5 метр гүнтэй галын аюулгүйн зурвасыг татаж дуусгасан.	100	
12	Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийг “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга”-д хамруулах	2016-2020	УУХҮЯ ТБГ	Улсын төсөв 2.5	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны 1-р сарын 12-ны өдрийн А/06 дугаар тушаалаар “Эрдэс баялгийн гэрээний мээдээллийг ил тод болгох” үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулж, тус Ажлын хэсэг нийт 10 удаа хуралдаж одоогоор 363 гэрээг ил тод болгохоор бэлэн болгоод цахим хуудаснаа байршуулахаар бэлтгэл ажил хийгдэж байна. Тус хэлэлцүүлгээс гаргасан Дүрмийн төслийн бүтэц, агуулгыг сайжруулах, олон улсын стандарт, монгол улсын хууль тогтоомж, мөрдөгдөж буй стандартад нийцүүлэхэд чиглэсэн санал, шүүмжийг дүрмийн төсөлд тусган боловсруулж байгаа ба дүрмийн төслийг Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хорооны хуралдаанаар хэлэлцүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд аж ахуй нэгжүүдийн “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга”-д хамрагдсан талаар судалгаа хийсэн ба гэрээлэгч компаниудыг ил тод байдлын санаачилгад хамрагдах	40	

						талаар зөвлөмж өгч ажилласан ба “Петрочайна Дачин Тамсар” ХХК, “Петро Матад” ХХК, “Сентрал Азиан Петролеум Корпорэйшн Лимитед” ХХК-иуд уг санаачлагад хамрагдаад байна.	
2.64. “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-ын 3.1.2-т заасан иргэд бичил уурхайн салбарт хууль ёсны бүтцээр хоршиж ажиллах чиглэлийг хэрэгжүүлэн холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно.	2	Хууль бусаар ашигт малтмал олборлогчдыг нэгдсэн зохион байгуулалтад оруулах ажлыг зохион байгуулах	2016-2020	УУХҮЯ БХЗГ	-	Бичил уурхайн холбогдох хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжилтийг хангах, хувиараа ашигт малтмал олборлох хууль бус үйл ажиллагааг бичил уурхайн зохион байгуулалтад оруулах, албажуулах, байгаль орчны хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор МХЕГ, ЦЕГ, АМГТГ-тай хамтран ажиллаж байна. Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн Ажлын хэсэг байгуулах тухай №322-А/242 тоот хамтарсан тушаалын дагуу Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2018 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 01/02 тоот хяналт шалгалтын удирдамж батлагдсан бөгөөд Налайх дүүргийн нутаг дэвсгэрт нүүрс олборлолт явуулж байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хамтран хийж гүйцэтгэсэн. Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн Ажлын хэсэг байгуулах тухай 308 тоот тушаалын дагуу Налайх дүүргийн нутаг дэвсгэрт хууль бусаар нүүрс олборлож байгаа иргэдийн эрүүл мэнд, амь нас хохирох явдлыг таслан зогсоох, санал зөвлөмж гаргах зорилгоор тус дүүргийн иргэдийн дунд зөвлөлдөх санал асуулга зохион байгуулах ажлын хэсэгт холбогдох саналыг хүргүүлэн ажилласан. МХЕГ-т болон хууль бусаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаа ихээр төвлөрсөн Архангай, Төв, Сэлэнгэ аймгуудын хяналт, мониторингийн ажлын үр дүнг нэмэгдүүлэх, МХЕГ-ын мэдээллийн системд мэдээлэл оруулах ажлын чанарыг сайжруулах зорилгоор 4 ширхэг дрон программ хангамж, GPS-ийн хамт Тогтвортой бичил уурхай төслөөс нийлүүлэхээр Удирдах зөвлөлөөс шийдвэрлэсэн. <b>Биелэлт шинэчлээгүй</b>	70

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

2.65. Уул уурхайн дэд бүтцийн хөгжлийн урт хугацааны төлөвлөлт боловсруулж, салбар хоорондын уялдааг сайжруулна.	2	Уул уурхайн дэд бүтцийн хөгжлийн урт хугацааны төлөвлөлтийг хэрэгжүүлэхэд салбар хоорондын уялдаа холбоог хангах	2016-2020	УУХҮЯ БХЗГ		Дэд бүтцийн хөгжлийн төсөл хэрэгжүүлэх	ТНБД-ийн 2017.10.09-ний өдрийн А/134 дугаар тушаалаар "Уул уурхайн дэд бүтцийн хөгжлийн урт хугацааны төлөвлөлтийн баримт бичиг"-ийн төслийг боловсруулах ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгийн хүрээнд Сангийн яам, Эрчим хүчний яам, Зам, тээврийн хөгжлийн яам, холбогдох агентлагаас төлөөллийг оруулж, шаардлагатай мэдээллийг авч нэгтгэн, уул уурхайн дэд бүтцийн хөгжлийн хөтөлбөрийн төслийг боловсруулан салбар хоорондын уялдааг хангах чиг үүргийн дагуу Үндэсний хөгжлийн газарт 2018 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 01/2687 тоот албан бичгээр хүргүүлсэн.	40
2.67. Хоёрдогч ашигт малтмал ашиглах эрх зүйн орчинг бий болгож, уурхайн нөхөн сэргээлт, хаалтыг олон улсын жишигт хүргэнэ.	2	Уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн журмыг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулж мөрдүүлэх	2017-2018	УУХҮЯ УУБГ		Журам батлагдан мөрдөгдөж эхлэх	Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журмын төсөл, нөлөөллийн шинжилгээний тайлан боловсруулж, батлуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн А/88 дугаар тушаалаар байгуулсан. Ажлын хэсгийн хүрээнд "Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журам"-ын төслийг боловсруулахаар удаа дараа вакум орчинд ажиллан төслийг боловсруулж дуусгасан. Энэ хугацаанд Ажлын хэсгийн хурлыг тогтмол зохион байгуулж мөн СЕСМИМ төслийн хүрээнд зохион байгуулсан Канад улсын Бритиш Колумб мужын Эрчим хүч, уул уурхай, газрын тосны нөөцийн яамны төлөөлөгчдтэй цуврал уулзалт, семинар, сургалтад оролцож санал, бодлоо солилцож "Бритиш Колумб мужийн Байгаль орчны нөхөн сэргээлтийн баталгаа, эрх зүйн зохицуулалт, туршлага" сэдэвт семинарын хүрээнд туршлага судлан ажилласан. Журмын төслийг эцэслэн боловсруулж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдаар батлуулан, БОАЖ-ын сайдаар батлуулахаар 2018 оны 12 дугаар сард хүргүүлээд байна.	70
2.69. Алтны олборлолтыг нэмэгдүүлж, бичил уурхай эрхлэгчдийн олборлосон алтыг худалдан авах эрх зүйн	2	Хөтөлбөр батлагдсантай холбогдуулан холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах	2017-2018	УУХҮЯ ГБГ		Хууль тогтоомжийн төслүүдийг боловсруулан, батлуулах	Алтны татварын эрх зүйн орчинг тогтвортой байлгах үүднээс Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, үзэл баримтлал, урьдчилсан тандан судалгааны хамтаар боловсруулж Засгийн газрын 2018 оны 10-р сарын 31-ний өдрийн 45 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжигдсэн. Хуулийн төслийг 2018 оны 12-р сарын 20-ны өдрийн УИХ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхээр өргөн барьсан. УУХҮС-ын 2018 оны 2-р сарын 13-ны өдрийн А/28 дугаар тушаалаар "Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам"-ыг, Эрдэс	100

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

орчинг бүрдүүлнэ.							<p>баялгийн мэргэжлийн зөвлөлийн "Дүрэм аргачлал батлах" тухай УУХҮС-ын 2018 оны 2-р сарын 26-ны А/46 дугаар тушаалаар дүрэмд холбогдох өөрчлөлт оруулж ордын нөөцийг бүртгэж эхэлсэн. "Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030", "Алт-2" хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор төрийн өмчит "Эрдэнэс Монгол" компанийн 100%-ийн эзэмшлийн "Эрдэнэс алт ресурс" компанийг байгуулан үйл ажиллагааг дэмжин ажиллаж байна. Хөтөлбөрийн хүрээнд алт олборлолтыг нэмэгдүүлэх зорилгоор санаачлан Монгол Улсын хэмжээнд "Эх орныхоо алтыг эрдэнэсийн сандаа" аяныг Монголбанкттай хамтран 5 сарын хугацаанд амжилттай зохион байгуулж алт тушаалтын хэмжээг 1.9 тн-оор нэмэгдүүлсэн. Энэ ажлын хүрээнд Дархан-Уул, Баянхонгор аймагт алт худалдан авах, сорьц тогтоох нэг цэгийн төвийг 265 сая төгрөгийн өртөгтэйгөөр байгуулагдаж орон нутагт алтыг худалдан авч эхэлсэн. Хөтөлбөрийн хүрээнд санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд Хөгжлийн банктай хамтран ажиллахаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны А/249 дугаар тушаалаар ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг батлуусан.</p>	
3	Алтны геологийн судалгаа, эрэл-үнэлгээ, хайгуулын ажлын хэмжээг өсгөн нөөцийг тогтвортой нэмэгдүүлэх	2017-2018	УУХҮЯ ГБГ	Батлагдсан - 1740.0 Гүйцэтгэл – 1528,0 Санхүүжилт - 1528,0	Улсын төсөв 1,000.0	Хэтийн төлвийн үнэлгээ хийх, алтны ордын баялаг, нөөцийн хэмжээг тогтоох	<p>- Монгол орны төв, зүүн бүсийн алтны нөөцийн хэтийн төлвийн үнэлгээ хийх геологийн судалгааны ажлын "ТЗМ-Алт-2017" төслийн төсөв, төлөвлөгөөг УУХҮС-ын 2018 оны А/03 дугаар тушаалаар батлуулсан. Төслийн 2018 оны төсвийн тодотголыг ЭБМЗ-ийн 4-р сарын 12-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж батлуулсан.</p> <p>Энэ оны хээрийн судалгааны ажлыг 5-р сарын 15-аас эхлүүлсэн бөгөөд Төслийн хээрийн судалгааны ажлыг Дорнод, Хэнтий, Сүхбаатар, Говь-Сүмбэр аймгийг бүрэн, Сэлэнгэ, Төв, Дундговь аймгийн зүүн хэсэг, Дорноговь аймгийн хойд, зүүн талын сумдыг хамруулан гүйцэтгэсэн бөгөөд нийтдээ 320000 км2 талбайг хамруулан эрэл-шалгалтын ажлыг 3336 цэгт хийж, мэдээллийн санг үүсгэсэн. Хэтийн төлөв бүхий зарим талбайд геофизик, геохими, геологи, геоморфологийн судалгааг хийж үр дүнг боловсруулж байна. 2018 онд алтны үндсэн 5 ордын 18,697.90 кг, шороон 42 ордын 4,600.56 кг буюу нийт 23,298.46 кг алтны нөөцийг Улсын нөөцийн бүртгэлд бүртгэсэн.</p>	100
6			УУХҮЯ		-			70

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

	Ашиглалтад оруулахад бэлэн болсон алтны уурхай, баяжуулах үйлдвэрийг байнгын ашиглалтад оруулахад дэмжлэг үзүүлэх	2016-2020	БХЗГ		Алтны олборлолтын хэмжээ нэмэгдэх	2018 онд Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсэгт заасны дагуу Булган аймгийн Бүрэгхангай сумын нутагт орших “Тэргүн майнинг” ХХК-ийн, Төв аймгийн Заамар сумын нутагт орших “Эм Жи Жи И Си” ХХК, “Их ундарга майнинг” ХХК-ийн, Дархан-Уул аймгийн Шарын гол сумын нутагт орших “Хатантүшиг трейд” ХХК-ийн алтны шороон ордын уурхайнуудыг байнгын ашиглалтад Улсын комисс хүлээн авсан. ???	
7	Бичил уурхай төвлөрсөн нутаг дэвсгэрт алтны худалдааны нэг цэгийн үйлчилгээ байгуулах талаар судалж хэрэгжүүлэх	2016-2019	УУХҮЯ БХЗГ		Холбогдох байгууллагад асуудлыг танилцуулж шийдвэрлүүлэх	Сайдын 2018.02.26-ны өдрийн А/47 дугаар тушаалаар байгуулагдсан “Алтны нийлүүлэлтийн сүлжээг боловсронгуй болгох” үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж алтны сорьц тогтоох, худалдан авах нэг цэгийн үйлчилгээний төвийн байршлыг хуралд оролцогчид Баянхонгор болон Дархан-Уул аймгууд байх нь зүйтэй гэж 100 хувийн саналаар баталсан. “Алт-2” хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор төрийн өмчит “Эрдэнэс Монгол” компанийн 100%-ийн эзэмшлийн “Эрдэнэс алт ресурс” компанийг байгуулан үйл ажиллагааг дэмжин ажиллаж байна. Хөтөлбөрийн хүрээнд алт олборлолтыг нэмэгдүүлэх зорилгоор санаачлан Монгол Улсын хэмжээнд “Эх орныхоо алтыг эрдэнэсийн сандаа” аяныг Монголбанктай хамтран 5 сарын хугацаанд амжилттай зохион байгуулж алт тушаалтын хэмжээг 1.9 тн-оор нэмэгдүүлсэн. Энэ ажлын хүрээнд Дархан-Уул, Баянхонгор аймагт алт худалдан авах, сорьц тогтоох нэг цэгийн төвийг 265 сая төгрөгийн өртөгтэйгөөр байгуулагдаж орон нутагт алтыг худалдан авч эхэлсэн.	100
2.70. Газрын тосны олборлолтыг тогтвортой нэмэгдүүлэн, газрын тос боловсруулах үйлдвэр байгуулна.	4	Барилгын ажлыг гүйцэтгэж, үйлдвэрийг хүлээн авч ашиглалтад оруулах	2017-2020	УУХҮЯ ХҮБГ	Гадаад зээл 800,000.0 Үйлдвэрийн барилгын ажил явагдах	ЗГ-ын 2018 оны 2 дугаар тогтоолоор үйлдвэрийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажилд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг МУ-ын Хөгжлийн банкнаас санхүүжүүлэх шийдвэр гарсантай холбогдуулан УУХҮЯам, ТӨБЗГ, Хөгжлийн банк болон Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК нар дөрвөлсөн Зээлийн болон Барьцааны гэрээг 2018 оны 04 дүгээр сарын 13-ний өдөр байгуулсан. Үйлдвэрийн гаднах дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлын хүрээнд “Сайншанд-Газрын тос боловсруулах үйлдвэр” хүртэлх салаа төмөр замын ажлын Ерөнхий гэрээг 2018 оны 03 дугаар 30-ны өдөр “УБ Төмөр зам” ХНН, хатуу хучилттай автозамын ажлын Ерөнхий гэрээг 2018 оны	70

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

						01 дүгээр сарын 31-ний өдөр Батлан хамгаалах яам, цахилгаан дамжуулах агаарын шугамын ажлын Ерөнхий гэрээг 2018 оны 03 дугаар сарын 06-ний өдөр “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-тай “Монгол газрын тос болоовсруулах үйлдвэр” ТӨХК тус тус байгуулсан. Төмөр зам, авто замын ажлын гүйцэтгэл 40%, цахилгаан дамжуулах агаарын шугамын ажил 90%-ийн тус тус гүйцэтгэлтэй байна. Дэд бүтцийн бүтээн байгуулалтанд Хөгжлийн банкнаас нийт 53,0 тэрбум төгрөгийн зээлийг олгосон байна.	
2.71. Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэр байгуулах ажлыг дэмжиж ажиллана.	3	Үйлдвэр байгуулж, ашиглалтад оруулах	2017-2020	УУХҮЯ ХҮБГ	Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт 862,400.0	УУХҮЯ-ны дэргэдэх "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах төсөл" хэрэгжүүлэх нэгж үйлдвэрийн урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулан УУХҮЯ-ны дэргэдэх "Эрдэс баялагийн мэргэжлийн зөвлөл"-өөр 2018.08.14-ний өдөр хэлэлцүүлэн дүгнэлт гаргуулсан. Төслийн Байгаль орчны ерөнхий үнэлгээний тайланг мэргэжлийн байгууллагаар хийлгэн 2018.05.20-нд хүлээн авсан бөгөөд уг тайланг БОАЖЯ хянан үзэж 2018.11.27-ны өдрийн 13/8361 дугаартай албан бичгээр дүгнэлт гаргаж ирүүлсэн. Үйлдвэр барих зорилгоор Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дэвсгэрт 466 га газрыг төсөл хэрэгжүүлэх зориулалтаар “Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай” тогтоолын төслийг боловсруулж Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлсэн. Барилга, хот байгуулалтын яам нь тогтоолын төсөлд яамдаас санал авч, 2018.12.12-ны өдрийн Засгийн газрын 378 дугаар тогтоолоор батлуулсан. Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих төслийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, уг төслийг хэрэгжүүлэгч нэгжид дэмжлэг үзүүлэх зорилгоор төслийн хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулахад хууль, санхүүгийн гадаад, дотоодын зөвлөхийг сонгон шалгаруулах тендерийг 2018.08-10 сард зохион байгуулсан. Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих төслийн хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах хууль, санхүүгийн зөвлөх үйлчилгээний гэрээг 2018.11.27-ны өдөр “Өмгөөллийн Монгол өмгөөлөгч” ХХН-тэй байгуулж, явцын тайланг хүлээн аваад байна.	40
2.72. Дархан, Сэлэнгийн бүсэд хар төмөрлөгийн цогцолбор байгуулах	3	Төмөртэйн уурхайд хуурай болон нойтон соронзон баяжуулах	2017-2018	УУХҮЯ ХҮБГ	Үйлдвэр ашиглалтад орох	Дэлхийн банкны “Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл”-ийн хүрээнд “Дархан-Сэлэнгийн бүс нутагт хар төмөрлөгийн цогцолборыг дэд бүтцийн хамт байгуулах төсөл”-ийн техник-эдийн засгийн үндэслэлийг Канад Улсын “Hatch” компани хийж гүйцэтгэн 2017.09 дүгээр сард ажлын хэсэгт танилцуулан холбогдох засваруудыг оруулж хүлээн авсан. Байгаль орчин,	/-/

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

нөхцөлийг бүрдүүлнэ.		үйлдвэр байгуулах					нийгмийн нөлөөллийн үнэлгээ"-ний урьдчилсан судалгааны тайланг Монгол Улсын "Экотон", болон "Ажид", "Экосфер" ХХК-иудын түншлэлийн баг боловсруулан ажиллаж байна. Төслийн ТЭЗҮ-д тусгасгаар Төмөртэйн уурхайд нэмэлтээр байгуулах хуурай болон нойтон соронзон баяжуулах үйлдвэрийн барилгын ажлыг 2018 оны 8 дугаар сард эхлүүлж 2020 оны 9 дүгээр сард дуусган мөн оны 12 сард үйлдвэрийг бүрэн ашиглалтанд хүлээлгэн өгөхөөр тусгасан. Одоогийн байдлаар санхүүжилтын асуудал шийдэгдээгүй тул Төмөртэйн уурхай дээр шинээр байгуулах хуурай болон нойтон соронзон баяжуулах үйлдвэрийн барилгын ажлыг эхлүүлэх ажил хойшлогдоод байна.	
	4	Шууд ангижруулсан төмрийн үйлдвэр байгуулах	2018-2020	УУХҮЯ ХҮБГ		Үйлдвэрийн барилгын ажил эхлэх	Уул уурхай хар төмөрлөгийн цогцолбор" байгуулах төслийг 2 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ба 1-р шатны ажлууд болох төмрийн хүдрийн ордуудаа эдийн засгийн эргэлтэнд оруулах, уул уурхайн үйлдвэрлэлийг дэд бүтцийн хамт байгуулах ажлуудыг амжилттай хэрэгжүүлэн төмрийн хүдрийн 2 уурхай нээж, уурхайнууд дээр хуурай соронзон баяжуулах үйлдвэрүүд, гангийн үйлдвэрийн дэргэд нойтон баяжуулах үйлдвэр зэргийг дэд бүтцийн хамт барьж байгуулаад байна. Төслийн 2-р шатанд шууд ангижруулсан төмрийн үйлдвэр, гангийн үйлвэрийг өгтөгтөх, шинэ гангийн үйлдвэр байгуулах ажлууд хийгдэх юм. Энэ ажлын хүрээнд төмрийн хүдрээс ган гарган авах технологийн судалгаа, түүхий эд, материалын болон технологийн туршилтууд, шууд ангижруулсан төмрийн үйлдвэрийн урьдчилсан ТЭЗҮ-ийн судалгааны ажлуудыг хийгээд байна. Шууд ангижруулсан төмрийн үйлдвэрийн бүтээн байгуулалтанд шаардлагатай хөрөнгө оруулалт шийдэгдээгүй байна.	/-/
	6	Гангийн үйлдвэрлэлийн бизнесийн таатай орчныг бүрдүүлж, төмөрлөгийн үйлдвэрүүдийн ашиглалтыг сайжруулах, импортын хэмжээг бууруулах	2017-2020	БХБЯ ХҮБГ		Төр, хувийн хэвшлийн түншлэл 100,000.0  Төмөрлөгийн үйлдвэрүү дийн ашиглалт сайжирч, барилгын салбар дахь гангийн	"Бэрэн групп" ХХК нь Орхон аймагт жилд 200 мянган тонн ган хайлах хүчин чадалтай үйлдвэрийг 2019 оны 2 дугаар улиралд ашиглалтад оруулахаар ажиллаж байна. Цогцолборын цувимал бүтээгдэхүүний үйлдвэрийн барилга угсралтын ажлыг 2017 оны 11 дүгээр сард дуусгасан ба тоног төхөөрөмжийн суурийн цутгалтын ажлыг 2019 оны 6-р сард дуусгахад төлөвлөсөн байна. Тоног төхөөрөмжийн угсралтын ажлыг эхлүүлэх бэлтгэл ажлууд хийгдэж, 2019 онд дуусган туршилт-зүгшрүүлэлтийн ажлыг эхлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Үйлдвэр ашиглалтад орсноор дотоодын гол нэр төрлийн ган бүтээгдэхүүний хэрэглээний 50 хүртэл хувийг хангах боломжтой болох юм.	/-/

					импортын хэмжээ буурах		
2.73. Нүүрс угаах, гүн боловсруулах үйлдвэр болон нүүрсний нийлэг хийн үйлдвэр байгуулахыг бодлогоор дэмжинэ.	5	Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэрийн нарийвчилсан ТЭЗҮ, барилгын зураг төсөл боловсруулах, барилгын ажлыг гүйцэтгэж, үйлдвэрийг хүлээн авч ашиглалтад оруулах	2018-2020	УУХҮЯ ХҮБГ	Барилгын ажил эхлэх	БНХАУ-ын Үндэсний газрын тосны корпораци (CNPC)-ийн охин компани болох “Хуан Чү барилга угсралт, инженеринг” компани (НQC) болон “Хятадын газрын тосны шугам хоолой” компанитай (СРР) төсөл дээр хамтран ажиллах хөрөнгө оруулалт хийх чиглэлээр “Хамтран ажиллах санамж бичиг” байгуулахаар санамж бичгийн төслийг боловсруулаад байна. Бүтээгдэхүүн худалдан авах, төсөлд хамтран ажиллах асуудлаар Улаанбаатар хотын Хөгжлийн корпорацитай 2018.09 дүгээр сард хамтын ажиллагааны Санамж бичиг байгуулсан. “Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр”-ийн байршлыг тогтоож, үйлдвэрийн газрын талаар Төв аймгийн Баяндэлгэр сумын 2017.12.18-ны өдрийн ИТХ-ын хуралдаанд танилцуулан 2018 оны сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулсан. Түүнчлэн үйлдвэрийн газрын асуудлыг Төв аймгийн ИТХ-ын 2018.01.12-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн уг өдрийн 08 дугаар тогтоолоор байршил болон хэмжээг тогтоож, Аймгийн тусгай хэрэгцээнд оруулах ажлыг зохион байгуулсан. Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр”-ийн төслийн дамжуулах хоолойн трассыг тогтоох ажлын хүрээнд Төв аймгийн ИТХ-ын 2018.01.12-ны өдрийн 08 дугаар тогтоолоор Хийг дамжуулах шугам хоолойн трассын байршлыг нарийвчлан тогтоож, хий дамжуулах хоолой дайран өнгөрөх газрыг Аймгийн тусгай хэрэгцээнд авсан. “Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр”-ийн төслийн 2018 оны үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор “Улаанбаатар хотын байгалийн хийн түгээх шугам сүлжээний трасс, технологийн судалгаа” хийх зөвлөх үйлчилгээг үзүүлэх нээлттэй тендер 2 удаа зарлагдсан боловч ажлын даалгаврын шаардлага хангасан хуулийн этгээд оролцоогүй тул үнэлгээний хорооны ажлын хэсэг тендерийг хүчингүй болсон тухай дүгнэлтийг захиалагчид танилцуулснаар 2019 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд оруулж дахин тендер зарлахаар төлөвлөөд байна.	40



							Төслийн хүрээнд төслийн нэгжийн ажилтнууд Нийслэлийн ЗДТГ болон Улаанбаатар хотын дүүргүүдтэй хамтран ажиллаж, хотын дулаан хангамжийн ерөнхий төлөвлөлттэй холбоотой баримт материал, зураг схемийг цаасан болон цахим хэлбэрээр хүлээн авч, боловсруулан холбогдох урьдчилсан судалгааны ажлыг хийгээд байна. Мөн Нийслэлийн ЗДТГ-ын Хот төлөвлөлтийн газартай хамтран Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөө, дахин төлөвлөлтөд 2, 3-р бүсийн айл өрхийн дулааны эх үүсвэрийг хийн түлшээр хангахад шаардагдах хийн түгээх шугам хоолойн асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар уулзалт зохион байгуулж, холбогдох санал зөвлөмжийг авч дээрх судалгааны ажилд тусган ажиллаж байна.	
2.74. Шингэрүүлсэн түлш, шатах тослох материалын үйлдвэр байгуулах ажлыг бодлогоор дэмжинэ.	1	Улаанбаатар хотод жилд 15,000 тн тос, тосолгооны материал үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэр байгуулахыг дэмжих	2016-2019	УУХҮЯ ХҮБГ		-	“Тос, тосолгооны материалын эрэлт, нийлүүлэлт, үйлдвэрлэл, технологи”-ийн чиглэлээр урьдчилсан судалгааны материалыг бэлдэж удирдлагад танилцуулсны дагуу холбогдох дэлгэрэнгүй судалгааны ажлыг мэргэжлийн судалгааны байгууллагаар гүйцэтгүүлэхээр шийдвэрлэн, түүнд шаардагдах зардлыг УУХҮЯ-ны 2019 оны Эрдэм шинжилгээний, судалгааны ажлын төсөвт суулгаад байна. Мөн "Интер стандарт нефть" ХХК-ийн тос тосолгооны материал үйлдвэрлэх төслийг дэмжиж Төслийн нийт хөрөнгө оруулалтын 20%-ийг Хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлэхээр урьдчилсан байдлаар тус банктэй тохиролцож, саналыг бичгээр хүргүүлээд байна.	40
2.75. Метал хийц, угсралтын үйлдвэрийг хөгжүүлнэ.	1	Автомашин, хөдөө аж ахуйн тоног төхөөрөмж, машин механизм угсрах, автомашины эд анги үйлдвэрлэх үйлдвэр, технологийн парк байгуулахыг дэмжих	2017-2020	УУХҮЯ ХҮБГ		-	“Автомашин, машин механизм угсрах, автомашины эд анги үйлдвэрлэх үйлдвэрлэл, технологийн парк байгуулах боломж нөхцөл” сэдэвт зөвлөх үйлчилгээний Үнэлгээний хороо 2018.04.24-ний өдөр хуралдаж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан бөгөөд гүйцэтгэгчээр шалгарсан ШУТИС-ийн Механик, тээврийн сургуультай 2018.05.17-ны өдөр зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулан ажиллаж байна. Энэхүү ажлын хүрээнд судалгааны ажлын эцсийн тайланг 2018.12.13-ны өдөр хүлээн авав.	70

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

2.92. Цэвэрлэх байгуулам жаар цэвэрлэсэн ус болон хөрсний усыг үйлдвэрийн технологийн хэрэгцээнд ашиглах боломжийг бүрдүүлнэ.	2	Хөрсний усыг үйлдвэрийн технологийн хэрэгцээнд ашиглах чиглэлээр судалгаа хийх	2016-2018	БХБЯ БХЗГ	Судалгааны үр дүнг хэлэлцүүлэх	ШУТИС-ын дэргэдэх Усны судалгааны төвөөс Хөрсний усыг үйлдвэрийн хэрэгцээнд ашиглах, энэ чиглэлээр судалгаа хийхэд шаардагдах төсөв, хөрсний усыг ашиглах төслийн саналыг үндсэн хэрэгжүүлэгч БХБЯ-нд ирүүлсэн ба асуудлыг судалж байна.	/-/
2.99. Шивээ-Овоо, Тэвшийн говь болон бусад нүүрсний ордыг түшиглэн экспортын зориулалттай том чадлын цахилгаан станц, тогтмол гүйдлийн цахилгаан дамжуулах шугам барих төслийг эхлүүлнэ.	3	Хашаат цав, Тэвшийн говийн орд газруудыг түшиглэн том чадлын цахилгаан станц, тогтмол гүйдлийн цахилгаан дамжуулах шугам, нүүрсний уурхай байгуулах төслүүдийг эхлүүлэх	2018-2020	ЭХЯ БХЗГ	Төслийн суурь судалгааны ажилд дэмжлэг үзүүлэх	Тэвшийн говийн нүүрсний ордыг түшиглэн цахилгаан станц байгуулахаар концессын гэрээ байгуулагдсан ба Үндэсний хөгжлийн газар хариуцан ажиллаж байна.	/-/
<b>ГУРАВ. НИЙГМИЙН БОДЛОГЫН</b>							
3.2.33. Шинжлэх ухаан, технологи, инновацийн салбарт олон улсын жишигт нийцсэн	10	Уул уурхай, шинжлэх ухааны чиглэлд бүх нийтийн боловсролыг дээшлүүлэх хүрээнд	2018	ЦЭКАА БХЗГ	Шинжлэх ухаан, танин мэдэхүйн мэдээллийн төвийн байрны асуудлыг шийдвэрлүүлэх	Толгойлон хэрэгжүүлэгч ЦЭКАА-аас биелэлт гарна.	/-/

барилга, байгууламж, лабораторын орчин нөхцөл бүхий дэд бүтцийг бий болгохыг дэмжинэ.		Шинжлэх ухаан, танин мэдэхүйн мэдээллийн төв байгуулах барилга, байгууламжийн асуудлыг шийдвэрлэх				, ТЭЗҮ-ийг батлуулах		
<b>ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН</b>								
4.1.3. Байгаль орчны багц хуулийг хэрэгжүүлэх цогц арга хэмжээ авч, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй үйлдвэрлэл, үйлчилгээ болон байгалийн нөөцийн хууль бус ашиглалтад тавих хяналтыг сайжруулна.	1	Байгаль орчны үнэлгээ, аудитаар дамжуулан ашиглагч нь байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэх	2016-2020	БОАЖЯ БХЗГ		200-250 төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянан баталж, хэрэгжилтийг хангуулах	БОАЖЯ-ны Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний Мэргэжлийн зөвлөлийн хуралд яамны төлөөллийг оролцуулж, 21 удаагийн хуралдаанаар төслүүдийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, Байгаль орчны менежментийн тайлан, төлөвлөгөөг баталсан байна.	100
4.2.3. Усны нөөцийг хамгаалж, хомсдолоос сэргийлэх нэгдсэн менежментийг хэрэгжүүлж, хаягдал бохир усыг цэвэрлэн	2	Ус ашиглалтыг бүрэн тоолууржуулж, хаягдал бохир усыг цэвэрлэж, дахин ашиглалтыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах	2017-2020	БОАЖЯ БХЗГ		Усны тоолууртай ус ашиглагчийн тоо болон ус эргүүлэн ашиглалт, дахин ашиглалтыг дэмжиж нэмэгдүүлэх	Толгойлон хэрэгжүүлэгч БОАЖЯ-аас биелэлт гарна.	/-/

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

дахин ашиглах технологи нэвтрүүлэхийг дэмжинэ.							
4.2.6. Хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах бодлого хэрэгжүүлж, уул уурхайн хайгуул, олборлолтод өртөж, эвдрэлд орсон газар нутгийг нөхөн сэргээнэ.	1	Уул уурхайн улмаас эвдэрсэн газрын хохирлыг тооцох, нөхөн сэргээх эрх зүйн зохицуулалтыг бий болгох, нөхөн сэргээлт хийх	2016-2020	БОАЖЯ БХЗГ	Уул уурхайн улмаас эвдэрсэн газрын хохирлыг тооцох, нөхөн сэргээх эрх зүйн орчныг бүрдүүлэх	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын А/85 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг нийт 21 аймагт бүсчилэн 10 чиглэлд орон нутагт томилолтоор ажиллаж, орон нутгийн удирдлага, аж ахуйн нэгжийн төлөөлөлтэй уулзалт хийж, чиглэл хүргүүлсэн. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны А/90 тоот тушаалаар Орон нутгийн хөндөгдсөн газарт нөхөн сэргээлт хийлгэхтэй холбоотой үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан ажиллаж байна. Мөн БОАЖС-д хамтарсан ажлын хэсэг байгуулж ажиллах санал хүргүүлсэн. БОАЖЯ-аас 2018 оны 10 дугаар сарын 22-23-ний өдрүүдэд зохион байгуулсан, “Байгаль хамгаалал ба уул уурхайн нөхөн сэргээлт” үндэсний сургалт, семинарт АМГТГ-ын төлөөлөл оролцож, нөхөн сэргээлтийн хуулийн төсөл, байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянах, хүлээн авах журамд орох өөрчлөлтийн төслийг танилцуулан хэлэлцсэн. Мөн MIRECO төслийн хүрээнд дээрх хуулийн төсөлд холбогдох саналыг өгсөн. Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгад уул уурхайн нөхөн сэргээлтийн үндсэн суурь харилцааг зохицуулах, холбогдох хуулийн төслүүдийн үзэл баримтлал хуулийн төслүүдийн уялдаа холбоог хангах, байгаль орчны хохирол тооцох асуудлыг цогц байдлаар шийдвэрлэх талаар санал тайлбар хүргүүлсэн.	70
	3	Аж ахуйн нэгж, мэргэжлийн байгууллагын үүрэг, хариуцлагыг өндөржүүлэх, чадавхийг бэхжүүлэх замаар нөхөн сэргээлтийн ажлын чанар үр дүнг дээшлүүлэх,	2017-2020	БОАЖЯ, МХЕГ БХЗГ	Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй ААН, газрын хэвлийн нөхөн сэргээлтийн мэргэжлийн байгууллага, нутгийн иргэдийн оролцоотойгоо р 300-аас	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын А/85 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг нийт 21 аймагт бүсчилэн 10 чиглэлд орон нутагт томилолтоор ажиллаж, орон нутгийн удирдлага, аж ахуйн нэгжийн төлөөлөлтэй уулзалт хийж, чиглэл хүргүүлсэн. Ажлын хэсгийн хүрээнд 2018.08.20-27-ны өдрүүдэд Сэлэнгэ аймгийн Хүдэр, Ерөө, Булган аймгийн Бүрэгхангай, Төв аймгийн Заамар сумдад томилолтоор ажилласан. Алтны салбарт үйл ажиллагаа эрхэлж байгаа зарим аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагаа, “Алт-2” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тулгамдаж байгаа асуудал, жилийн төлөвлөгөөний биелэлт болон хуулийн дагуу эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийсэн зэргийг газар дээр нь үзэж танилцан “Ийгл ТВ”-ийн “БОДИТ БАЙДАЛ” нэвтрүүлэгт аж ахуйн нэгжүүдийн нөхөн	70

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

	орон нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх				доошгүй га талбайд нөхөн сэргээлт хийх	сэргээлт хийсэн сайн туршлагын талаар мэдээлсэн. 2018 онд 11 аймгийн 29 сум, нийслэлийн 4 дүүргийн нутагт 69 тусгай зөвшөөрөлтэй ААН, 7 нөхөн сэргээлтийн мэргэжлийн байгууллага, 1 ТББ, 4 нөхөрлөл, 1 холбоо, 328 иргэн 617 га-д техникийн, 465 га-д биологийн нөхөн сэргээлтийн ажил хийсэн байна. Судалгааны дүнгээс харахад 2017 оны байдлаар 9 аймагт иргэдийн оролцоотой нөхөн сэргээлтийн ажил хийгдсэн бол 2018 онд 12 аймагт 300 гаруй иргэн ажилласан байна.	
4	Уул уурхайн сөрөг нөлөөллийг бууруулах дэд хөтөлбөр хэрэгжүүлж, холбогдох стандартуудыг шинэчлэх, сургалт, судалгааны төв байгуулах	2016-2020	БОАЖЯ БХЗГ		Уул уурхайн сөрөг нөлөөллийг бууруулах дэд хөтөлбөрийг батлуулж, холбогдох стандартыг шинэчлэх, аргачлал боловсруулж эхлэх	Үндсэн хэрэгжүүлэгч БОАЖЯ болон БНСУ-ын Уул уурхайн Нөхөн Сэргээлтийн Корпораци (MIRECO) хамтран БНСУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлж буй “Монгол улсад Уул уурхайн сөрөг нөлөөллийг бууруулах менежментийн чадавхийг бэхжүүлэх” төслийн Мастер төлөвлөгөө боловсруулах багт яамны төлөөлөл оролцож холбогдох санал өгч ажилласан.	70
5	Орхон, Туул гол болон бусад голуудын хамгаалалтын бүсэд ашигт малтмалын олборлолтын үйл ажиллагаа явуулж буй ААН-ийг хууль тогтоомжид нийцүүлэх арга хэмжээ авах, хариуцлагатай уул уурхайн зарчмыг мөрдүүлж усны	2016-2019	БОАЖЯ БХЗГ		Хамгаалалтын бүсэд явуулж байгаа үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт Ашигт малтмал, газрын тосны газрын төлөөлөл орж ажилласан бөгөөд шаардлагатай мэдээ, мэдээллээр хангаж ажилласан. Ажлын хэсэг нөхцөл байдалтай газар дээр нь танилцаж, хуулийн дагуу үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийг технологийн горимын дагуу үйл ажиллагаа явуулах талаар чиглэл, зөвлөмж өгч ажилласан бөгөөд энэ тухай саналыг ажлын хэсэгт хүргүүлсэн.	70

		бохирдлыг бууруулах						
6		Баруун бүсэд дүйцүүлэн хамгааллын жишиг төсөл хэрэгжүүлэх	2016- 2019	БОАЖЯ БХЗГ		Баян-Айраг, Хотгор, Хөшөөтийн орд газрын биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгааллын жишиг хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэх	Үндсэн хэрэгжүүлэгч БОАЖЯ-наас Даян дэлхийн байгаль хамгаалах сан /GEF/ НҮБХХ-ийн буцалтгүй тусламжтайгаар хэрэгжүүлж уй, Монгол орны баруун бүсэд хөгжлийн сөрөг нөлөөлөл, газрын доройтлыг бууруулах үе шат, дүйцүүлэн хамгааллыг ландшафтын түвшний төлөвлөлт, менежментэд нэвтрүүлэх замаар уул уурхайгаас бэлчээрт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилготой "Монгол орны баруун бүс нутгийн газрын доройтол, хөгжлийн сөрөг нөлөөллийг бууруулах, дүйцүүлэн хамгааллыг нэвтрүүлэх" төслийн Удирдах хороонд яамны төлөөлөл ажиллаж байна. Удирдах хорооны 2 дугаар хуралдаанд оролцсон. Төслийн хүрээнд Баян-Айраг, Хөшөөтийн уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулсан хохирлыг тооцож, дүйцүүлэн хамгааллын арга хэмжээнд төлөвлөсөн арга хэмжээ, түүний зардалд үнэлэлт, дүгнэлт өгөх, газрын доройтлыг бууруулах дүйцүүлэн хамгаалах цаашдын арга хэмжээний цар хүрээг тодорхойлон улмаар орон нутагт чадавхижуулах сургалтыг удаа дараа зохион байгуулан холбогдох уурхайнуудын биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгааллын хөтөлбөрийн төслийг хэлэлцэн, эцэслэн боловсруулж уул уурхайн аж ахуйн нэгжид хүлээлгэн өгсөн байна.	70
<b>Хэрэгжилт /хувь/</b>								<b>75,8</b>

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН ГАЗАР

2019 он